



# ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД  
УЧИРСАН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ

---

ЦУВРАЛ СУДАЛГАА №3



# ХОХИРЛЫН ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД  
УЧИРСАН ХОХИРЛЫН НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ

ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН  
ДҮН ШИНЖИЛГЭЭ

ЦУВРАЛ СУДАЛГАА №3

Улаанбаатар хот  
2021 он

ННА 67.408  
ДАА 345  
Н-749



ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД УЧИРСАН ХОХИРЛЫН  
НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ: ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Судалгааны багийн бүрэлдэхүүн:

*Н.НОРОВСАМБУУ, МУИС-ийн ХЗС-ийн Хувийн эрх зүйн тэнхимийн багш*

*Ж.СОДНОМДАРЖАА, Монголын Хуульчдын Холбооны гишүүн өмгөөлөгч*

Тус тайлангийн үр дүн, дүгнэлт, санал зөвлөмж нь судлаачдын дүгнэлт бөгөөд  
Нээлттэй Нийгэм Форумын албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

ISBN: 978-9919-9678-9-5

© Нээлттэй Нийгэм Форум, 2021

Хаяг: Жамьян гүний гудамж  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240  
Утас: 976-76113207  
Вэб: <http://www.forum.mn>  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

## ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ .....	5
УДИРТГАЛ .....	6
СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ .....	8
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .....	10
Нэг. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ .....	11
1.1. Асуудал .....	11
1.2. Шүүхийн шийдвэр .....	14
1.3. Бусад улсын эрх зүйн зохицуулалт .....	16
1.3.1. Япон Улсын эрх зүйн зохицуулалт .....	16
1.3.2. ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт .....	17
Хоёр. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ ШААРДАХ ЭРХИЙН ҮНДЭСЛЭЛ .....	19
2.1. Асуудал .....	19
2.2. Шүүхийн шийдвэр .....	21
Гурав. ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ МАРГААН МӨН ЭСЭХ .....	28
3.1. Асуудал .....	28
3.2. Шүүхийн шийдвэр .....	29
Дөрөв. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХАД ТӨЛСӨН ХӨЛСИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ .....	35
4.1. Асуудал .....	35
4.2. Шүүхийн шийдвэр .....	35

Тав. ОЛОХ ЁСТОЙ БАЙСАН ОРЛОГЫГ ТООЦОХ .....	41
5.1. Асуудал .....	41
5.2. Шүүхийн шийдвэр .....	41
Зургаа. СЭТГЭЛ САНААНЫ ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ .....	49
6.1. Асуудал .....	49
6.2. Шүүхийн шийдвэр .....	49
6.2.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-р зүйлийн 1 дэх хэсэг материаллаг эрх зүй хэм хэмжээ болох нь .....	49
6.2.2 Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх эсэхтэй холбоотой шийдвэр .....	54
6.2.3 Сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудал .....	61
ДҮГНЭЛТ .....	66
ЗӨВЛӨМЖ .....	68
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ .....	70

## ӨМНӨХ ҮГ

Манай улсад 2012 оноос эхэлсэн Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн үндсэн чиглэлийн нэг нь хохирогчийг хамгаалах, хохирол барагдуулалтыг шинэ шатанд гаргах явдал билээ. Гэмт хэргийн хохирол, хор уршгийг шударгаар барагдуулах нь Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрх төдийгүй, нийгмийн эмзэг бүлгийн хохирогчдын эрхийг хамгаалах, гэмт хэрэгтэй үр нөлөөтэй тэмцэхэд чухал нөлөөтэй.

Нээлттэй Нийгэм Форум нь Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн энэхүү чухал зорилтын хэрэгжилтийг тал талаас нь нухацтай судлахыг зорьсон болно.

Энэ хүрээнд онцгой анхаарах нэг чиглэл бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөх асуудал билээ. Тус зохицуулалт нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45 дугаар бүлгээр зохицуулагдсан байдаг. Тиймээс практикт учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэрэг хэрхэн шийдвэрлэгдэж буйг судлаач Н.Норовсамбуу, Ж.Содномдаржаа нарын хийсэн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэрэг” судалгаагаар уншигч Танд хүргэж байгаадаа баяртай байна. Уг судалгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг төлүүлэхтэй холбоотой Улсын дээд шүүхийн 20 тогтоолд дүн шинжилгээ хийж, хохирол барагдуулж буй өнөөгийн практик, тулгамдаж буй асуудлыг судалснаараа ач холбогдолтой.

Энэхүү судалгаа нь хохирол барагдуулах тогтолцоог үнэлэх чиглэлээр хийгдэж буй цуврал судалгааны гурав дахь бөгөөд цаашид ч энэ сэдвийн хүрээнд илүү нарийвчилсан судалгаа, шинжилгээг уншигчдад хүргэхээр ажиллаж байна. Тиймээс уншигч Таны өгөх санал, шүүмж бидний цаашдын судалгааны ажилд онцгой үнэ цэнтэй байх болно.

Дашрамд дурдахад Нээлттэй Нийгэм Форум манай улсад өрнөж буй Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийг бодлогын судалгаа, мониторингоор дэмжихийг зорьж ирсэн бөгөөд энэ хүрээнд 10 гаруй судалгаа, шинжилгээг олны хүртээл болгоод байна.

ННФ-ын Гүйцэтгэх захирал П.Эрдэнэжаргал

## УДИРТГАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тогтолцоо нь нэг ёсны эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны баталгаа болдог. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар “үндэслэл бүхий сэжиг” байх тохиолдолд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах бөгөөд ийнхүү эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэм буруугүй хүнийг баривчлах, цагдан хорих, ял эдлүүлэх эрсдэлийг өөртөө агуулж байдаг. Иймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өртсөн гэм буруугүй этгээдийн хохирлыг нөхөн төлөх нь уг тогтолцооны гол зорилго болно.

Шүүхийн практикаас үзвэл, уг тогтолцооны эх үндсийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т “гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэсэн заалттай холбон тайлбарлаж, нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох зарчмын агуулгаар эрүүгийн гэмт хэрэгт шалгах эрх бүхий байгууллагын хууль ёсны ажиллагаа явагдсан хэдий ч эцэст нь тухайн этгээд гэм буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөлд дээрх ажиллагааны эрх зүйн үр дагаврыг төр хариуцах үүрэгтэй гэж үзэх байдал ажиглагдаж байна.

Гэвч Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэгт буруутгуулж буй хэн боловч гэм буруу нь хуулийн дагуу нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцогдох эрхтэй” гэхийн зэрэгцээ уг зүйлийн 6 дахь хэсэгт “Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд

хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ”<sup>1</sup> гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх зарчмыг тусад нь зохицуулсан байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т заасан шүүхээр нотлогдох хүртэл гэм буруугүйд тооцох зарчим нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах асуудалтай шууд холбоогүй болохыг анхаарах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, эдгээр нь тус тусдаа бие даасан зорилготой тогтолцоонууд юм. Харин эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах асуудлыг манай улсын Үндсэн хуулийн 14-т заасан “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх ...” гэсэн эрхтэй холбож үзэх нь илүү зохистой юм.

Тухайлбал, Япон Улсын 1946 онд батлагдсан Үндсэн хуулийн 40-р зүйлд “Аливаа этгээд баривчлагдсан, цагдан хоригдсоны дараа шүүхээр цагаатгагдсан бол хуульд заасны дагуу улсаас нөхөн төлбөр шаардах эрхтэй”<sup>2</sup> гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас үүссэн хохирол нөхөн төлөхийг шаардах эрх (刑事補償請求権)-ийг бие даасан үндсэн эрх болгож хүлээн зөвшөөрсөн байдаг.

---

<sup>1</sup> Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт <https://www.legalinfo.mn/law/details/1257>

<sup>2</sup> Article 40. Any person, in case he is acquitted after he has been arrested or detained, may sue the State for redress as provided by law.

第40条 何人も、抑留又は拘禁された後、無罪の裁判を受けたときは、法律の定めるところにより、国にその補償を求めることができる。<http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=174>



## СУДАЛГААНЫ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү судалгааны хүрээнд 2017 оны шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дөчин тавдугаар бүлгийн зохицуулалтыг Улсын Дээд Шүүх хэрхэн хэрэглэж байгааг авч үзэх болно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн Дөчин тавдугаар бүлэгт “хууль бус”, “хууль зөрчсөн” гэх нэр томъёог хэрэглэсэн байдаг. Энэ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд мөрдөгч, прокурор, шүүгчийн үйл ажиллагаа заавал хууль зөрчсөн байх шаардлагатай юу? эсвэл мөрдөгч, прокурор, шүүгчийн үйл ажиллагаа зохих хууль, журмыг зөрчөөгүй байсан ч хохирлыг нөхөн төлүүлэх үү? гэсэн асуулт руу хөтөлж байгаа юм.

Үүний дараагийн асуудал нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал бөгөөд энэ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэг, эсвэл Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.4 дэх хэсэгт заасантай холбоотой байж болохоор байна. Энэ хоёр заалтын аль нь хохирол нөхөн төлүүлэх шаардах эрхийн үндэслэл болох талаар дүн шинжилгээ хийх шаардлагатай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах нэхэмжлэлтэй маргааныг 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 397-р зүйлийн 397.1 дэх хэсэгт заасны дагуу онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэж ирсэн байдаг. Харин 2017 оны шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд уг төрлийн маргааныг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ гэж заагаагүй атал Улсын дээд шүүх (УДШ)-ийн зүгээс уг төрлийн маргааныг ердийн журмаар шийдвэрлэсэн доод шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн гэж үзэн онцгой ажиллагааны журмаар шийдвэрлүүлэхээр буцаасан тохиолдол гарсан нь анхаарал татаж

буй асуудал болно. Иймд уг төрлийн маргааныг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ гэсэн хуулийн тодорхой заалт байхгүй байхад яагаад заавал онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх ёстой болохыг тодруулах хэрэгтэй.

Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарч буй зардлыг шүүхийн зардал болон талуудын зардал гэж ангилдаг бөгөөд зарчмын хувьд талууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох зардлаа өөрсдөө хариуцах ёстой. Тухайлбал, хууль зүйн туслалцаа авсан өмгөөлөгчийн хөлсийг нэхэмжлэлийн шаардлага хангагдсан ч хариуцагчаас нөхөн гаргуулах боломжгүй юм. Харин Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.3-р зүйлийн 1 дэх хэсгийн 1.6 дахь заалтад “хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлс”-ийг эд хөрөнгийн хохиролд хамааруулан хуульчилсан байна. Энд хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг ямар нотлох баримтаар тогтоож байгааг тодруулах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээнд заасан үнийн дүнгээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж байна уу? эсвэл бодитоор өмгөөлөгчид төлсөн дүнгээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж байна уу? гэх асуултад хариулах ёстой.

Олох ёстой орлогыг тооцоход гэм хор учирсан үеийн үнэлгээг баримтлах уу?, эсвэл хэрэг хянан шийдвэрлэж буй үеийн үнэлгээг баримтлах уу? гэсэн асуудал гарахын зэрэгцээ хохирол учирсан хугацааг сэжиглэгдсэн үеэс тооцох уу?, эсвэл цагдан хорьсон гэх мэт эрх чөлөөг нь хязгаарласан үеэс тооцох уу? гэдгийг шийдвэрлэх ёстой болж байна.

Иргэний хуулийн 230-р зүйлийн 230.2 дахь хэсэгт зааснаар эдийн бус гэм хорыг хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санааны үр дагавар арилгуулах... эрхтэй”, 45.4-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санаанд учирсан хор уршиг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг ...хуульд заасан журмын дагуу гаргана” гэсэн нь хуульд тусгайлан заасан тохиолдол мөн эсэх дээр дүгнэлт өгнө.

## СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2016 оноос 2020 оныг хүртэлх 98,941 хэргийн (<http://www.shuukh.mn> цахим хуудаст байгаа) 141,651 шийдвэрээс хайлт хийхэд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой 33 хэрэгт холбогдох УДШ-ийн тогтоол байх бөгөөд мэтгэлцээн өрнөсөн, хууль тайлбарласан байдлыг нь харгалзан 20 тогтоолыг сонгон авч дүн шинжилгээ хийсэн болно. Уг хэргийг шийдвэрлэсэн УДШ-ийн тогтоолын 60-аас илүү хувьд нь дүгнэлт хийсэн тул уг төрлийн маргааныг шийдвэрлэж буй шүүхийн практикийг харуулахад хангалттай үзүүлэлт юм. 2016 оноос 2020 оны хооронд гарсан УДШ-ийн тогтоолыг сонгож авсан нь аль болох сүүлийн үеийн чиг хандлагыг харуулах зорилготой байв.

Судалгааны зорилтод дурдсан асуудлуудад дүн шинжилгээ хийхийн тулд асуудал тус бүрт 3-6 тохиолдлыг харьцуулж үзлээ. УДШ-ийн чиг үүрэг нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах, хуулийн зохицуулалтыг нэг мөр ойлгож, шүүхийн практикт зөв хэрэглэх явдлыг хангах тул хоёроос дээш тогтоолыг харьцуулж харахад нэг асуудал дээр ялгаатай байдлаар шийдвэрлэж байгаа эсэх нь харагдах ба 3-6 тогтоолыг харьцуулахад хангалттай гэж үзсэн.

УДШ-ийн шийдвэрт дүн шинжилгээ хийх явцдаа ХБНГУ, Япон Улсын хуулийн зарим зохицуулалтыг жишээ болгон оруулсан бөгөөд эдгээр улсын эрх зүйн зохицуулалт нь эх газрын эрх зүйн бүлийн орнуудад жишиг болохуйц өндөр хөгжсөн учраас сонгож авав.

Түүнчлэн ХБНГУ, Япон Улс нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлаар аль аль нь бие даасан хууль батлан гаргаж зохицуулж буй орнууд билээ. Эндээс эдгээр оронд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг заавал Иргэний хуулиар зохицуулах ёстой гэсэн баригдмал ойлголт байхгүй байгаа нь харагддаг.

# Нэг. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

## 1.1. АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах” гэсэн гарчиг нь нэр томъёоны хувьд хэт явцуу бөгөөд зорилгодоо нийцэхээргүй байдлаар тодорхойлогдсон байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэрхэн явагдах нь хуулиар тусгайлан эрх олгосон “шүүгч, прокурор, мөрдөгч” гэх субъектүүдээс шууд хамаарч байдаг. Тиймээс дээрх субъектээс өөр эрх олгогдсон, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг тусгайлан удирдах, хэрэгжүүлэх этгээд байхгүй тул тоочих нь зохимжгүй. Мөн “хууль зөрчсөн ажиллагаа” хэмээн томъёолсон нь зохицуулж буй харилцааг бүхэлд нь тодорхойлж чадахгүй байгаа, учир нь хууль бус, хууль зөрчсөн ажиллагаа, яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл шүүгдэгч, ял шийтгүүлсэн этгээдийг цагаатгасан бол хуулийн дагуу явагдсан ажиллагаа ч мөн адил хамаарахаар зохицуулсан. Энэхүү бүлгийн зорилго нь хууль бус эсэхээс үл хамааран эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах зорилготой байна.

Судлаачид эрүүгийн процессын эрх зүйн нийгмийн ач холбогдол, үнэлэмжийн нэгийг “Гэм буруугүй этгээд эрүүгийн хариуцлага, ял шийтгэл хүлээхгүй байх нөхцөл, журмыг тогтоож, хэрэв хүлээсэн бол ийм шийдвэрийг хүчингүй болгож, уг этгээдийг цагаатгах, учирсан хохирлыг нь нөхөн төлөх, арилгах бүхий л боломжийг баталгаажуулдаг”<sup>3</sup> гэж үзсэн байдаг.

---

<sup>3</sup> Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан “Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал” УБ хот, 2018 он, 12 дахь тал

Цаашлаад “хууль бус” гэх нэр томьёо нь энэ бүлгийн бүх заалтад тусгагдсан байна. Үүний улмаас хохирол нөхөн төлүүлэх гэм хорын маргаанд Төрийг төлөөлөн оролцож буй прокуроруудын зүгээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хууль ёсны байсан буюу мөрдөгч, прокурор, шүүгчийн үйл ажиллагаа хуульд заасан журмын дагуу явагдсан гэж тайлбар өгөх явдал түгээмэл байна.

---

**Прокурор Ч.А-ийн шүүхэд гаргасан тайлбарт:** ...Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль (2002)-д зааснаар нэхэмжлэгчийг тухайн үед зайлшгүй мөрдөж, хянан шалгах үндэслэл байсан бөгөөд энэ ажиллагааг хууль бусаар явуулаагүй.<sup>4</sup>

---

**Гуравдагч этгээд Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарт:** Ч.Г-ийг зорчигч тээврийн автобус осолдсонтой холбоотойгоор эрүүгийн хэрэгт шалгасан. Цагдаа, прокурорын байгууллага ЭБШХ-д заасан үндэслэл, журмын дагуу явуулсан. Түүнийг гэм буруугүй гэж хэргийг хэрэгсэхгүй болгоогүй, харин хангалттай тогтоогдоогүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон.<sup>5</sup>

---

**Гуравдагч этгээд Засгийн газрын төлөөлөгч Б.Онон, Б.Мөнгөнсүх, прокурор О.Сайнбаяр нарын шүүхэд гаргасан тайлбарт:** О.С нь талийгаач О.Б-ийн гэмтлийн шалтгааны талаар түүний хамаатны хүмүүс болон эмнэлгийн байгууллагын ажилтнуудад худал хэлж байсан нь тогтоогдсон. Талийгаачид анх шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийсэн шинжээчийн мэдүүлгээр учирсан гэмтэл нь автомашинаас унах үед үүсэх боломжгүй, цохилтын улмаас үүсэх боломжтой талаар мэдүүлсэн. О.С-ыг хуульд заасан журмын дагуу шалгаж, таслан сэргийлэх арга хэмжээ авсан.<sup>6</sup>

---

<sup>4</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6652/view>

<sup>5</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6360/view>

<sup>6</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5566/view>

---

**Гуравдагч этгээдийн шүүх хуралдаанд гаргасан тайлбарт:** Энэ үндэслэлээр ЭХХШТХ-ийн 45-р зүйлд заасны дагуу гэм хор учруулсан хохирлыг шаардсаныг зөвшөөрөхгүй. Учир нь гал гарч иргэдийн эд хөрөнгөд их хэмжээний хохирол учруулсан үйлдэлд зайлшгүй Эрүүгийн хэрэг үүсгэж шалгах шаардлагатай. Тухайн орон сууцны 6 давхарт гал гарсны улмаас дээшээ хөө тортог цохиж тухайн айлуудад засвар хийх шаардлагатай болж их хэмжээний хохирол учирсан. Мөрдөн байцаалтын ажиллагаа хийгдэж нотлох баримтыг хуульд заасан журмын дагуу баримтжуулсан. Гэрч, хохирогчид хууль сануулж мэдүүлэг авсан. Шүүх нотлох баримтын хүрээнд хэн нэгний нөлөөлөлд авталгүй хэргийг шийдвэрлэсэн.<sup>7</sup>

---

**Бие даасан шаардлага гаргаагүй гуравдагч этгээд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж оролцож буй Дорнод аймгийн Прокурорын газрын туслах прокурор Ц.Цэрмаагийн шүүх хуралдаанд гаргасан тайлбарт:** Нэхэмжлэгч О нь 1995 оны 2 сард Чулуунхороот сумын уурын зууханд хохирогч Батболдыг боож амь насыг нь хохироон уурын зууханд хийж шатаасан гэх гэмт хэрэгт холбогдсон. Тухайн үед мөрдөн байцаалтын ажиллагаа хуульд заасан үндэслэл журмын дагуу явагдсан.<sup>8</sup>

---

Нэгэнт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хууль бус” гэх нэр томьёог хэрэглэсэн тул ийнхүү буруугаар ойлгох явдал гарах нь гарцаагүй юм. Тиймээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгийн зохицуулалтуудаас “хууль бус”, “хууль зөрчсөн” гэх нэр томьёог хасах шаардлагатай.

Түүнчлэн эрүүгийн процесс ажиллагаа нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хамтын цогц ажиллагаа байдаг тул энэ бүлэгт мөрдөгч, прокурор, шүүгч гэж нэрлэн заах шаардлагагүй. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгийн зохицуулалтуудаас “мөрдөгч”, “прокурор”, “шүүгч” гэх нэр томьёог хасаж “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах” гэж нэрлэх нь зөв юм.

<sup>7</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5546/view>

<sup>8</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5338/view>

## 1.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР

УДШ-ийн зүгээс эрүүгийн гэмт хэрэгт шалгагдсаны улмаас үүссэн хохирлыг шаардах эрхийн урьдчилсан нөхцөлд шүүгч, прокурор, мөрдөгчийн үйл ажиллагаа хууль зөрчсөн ажиллагаа байхыг шаардахгүй гэж уг тогтолцооны зорилгод нийцүүлж хуулийг зөв тайлбарлан хэрэглэжээ.

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан дүгнэлт
1	2018 оны 12 сарын 06 Дугаар 001/ ХТ2018/01775 <sup>9</sup>	Төрөөс эрх олгогдсон тусгай албан тушаалтан, байгууллага эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хуулийн дагуу шалгах, хуульд заасан эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй хэдий ч ийнхүү зохих журмын дагуу явуулсан ажиллагааны үр дүнд тухайн этгээдийн гэм буруу нотлогдоогүй тохиолдолд дээрх эрхийн хязгаарлалт хууль бусад тооцогддог болно. Улмаар үүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг хуульд “хууль бус ажиллагаа”-нд хамааруулдаг.
2	2018 оны 03 сарын 13 Дугаар 001/ ХТ2018/00407 <sup>10</sup>	Эрүүгийн гэмт хэргийг шалгаж, тогтоох, яллагдагчаар татах, баривчлах, хорих арга хэмжээ авах, ял шийтгэх, ялыг эдлүүлэх эрх бүхий байгууллагын ажиллагаа хуулийн дагуу явагдсан хэдий ч тухайн этгээд гэм буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөлд түүний эрх зөрчигдсөн гэж үзэж, эрх зүйн үр дагаврыг төр хариуцах үүрэгтэй болно. Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 14-т “гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно” гэж заасан бөгөөд нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох зарчмын агуулгаар эрүүгийн гэмт хэрэгт шалгах эрх бүхий байгууллагын

<sup>9</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5344/view>

<sup>10</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/4040/view>

ажиллагаа зохих ёсоор явагдсан хэдий ч эцэст нь тухайн этгээд гэм буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөлд дээрх ажиллагааны эрх зүйн үр дагаврыг төр хариуцах үүрэгтэй байна.

---

3	2018 оны 03 сарын 13 Дугаар 001/ ХТ2018/00411 <sup>11</sup>	Эрүүгийн байцаан шийтгэх тухай 2002 оны хуулийн 388 дугаар зүйлийн 388.1-д, мөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д “хууль зөрчсөн ажиллагаа”-ны эрх зүйн үр дагаврын талаар заасан боловч энэхүү ажиллагаанд холбогдох албан тушаалтны хууль бус үйлдэл бүхий ажиллагаа хамаарахаас гадна яллагдагч гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсхүл шүүгдэгч, ял шийтгүүлсэн этгээдийг цагаатгасан бол хуулийн дагуу явагдсан ажиллагаа ч мөн адил хамаарна. Учир нь нотлогдоогүй бол гэм буруугүйд тооцогдох эрх зүйн презумпци нь иргэн бүрийг эрхийн үндэслэлгүй хязгаарлалтаас хамгаалах зарчим юм. Ийнхүү төрөөс эрх олгогдсон тусгай албан тушаалтан, байгууллага эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хуулийн дагуу шалгах, хуульд заасан эрхийн хязгаарлалтыг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй хэдий ч ийнхүү зохих журмын дагуу явуулсан ажиллагааны үр дүнд тухайн этгээдийн гэм буруу нотлогдоогүй тохиолдолд дээрх эрхийн хязгаарлалт хууль бусад тооцогддог болно. Улмаар үүнээс үүсэх эрх зүйн үр дагаврыг хуульд “хууль бус ажиллагаа”-нд хамааруулдаг.
---	--	---

---

Дээрх хүснэгтээс харвал УДШ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн” гэж заасанд анхаарал хандуулахгүй байх бөгөөд “төрөөс эрх олгогдсон тусгай албан тушаалтан, байгууллага эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдийг хуулийн дагуу шалгах, хуульд заасан эрхийн хязгаарлалтыг

<sup>11</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3844/view>



хэрэгжүүлэх бүрэн эрхтэй хэдий ч ийнхүү зохих журмын дагуу явуулсан ажиллагааны үр дүнд тухайн этгээдийн гэм буруу нотлогдоогүй тохиолдолд дээрх эрхийн хязгаарлалт хууль бусад тооцогддог болно” гэсэн дүгнэлттэй бүрэн санал нийлж байна. Учир нь тухайн этгээдийн гэм буруу нотлогдоогүй бол хохирлыг арилгах нь уг тогтолцооны гол зорилго юм.

### 1.3. БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

#### 1.3.1 Япон Улсын эрх зүйн зохицуулалт

1950 онд одоо хэрэгжиж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх хууль (刑事補償法<sup>12</sup>) батлагджээ.

---

<sup>12</sup> 刑事補償法（昭和二十五年法律第一号）施行日：令和二年四月一日 最終更新：平成二十九年六月二日公布（平成二十九年法律第四十五号）改正 [https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=325AC000000001](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=325AC000000001)

Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх хууль (刑事補償法)

1-р зүйл.

- 1.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн дагуу ердийн журмаар, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас болон тусгай хяналтын шатны шүүхэд гомдол гаргах ажиллагааны дагуу шүүхийн шийдвэрээр цагаатгагдсан этгээд нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль, Насанд хүрээгүй этгээдийн хууль, Эдийн засгийн судалгааны агентлагийн хуулиар баривчлагдсан, цагдан хоригдсон тохиолдолд улсаас хохирол нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.
- 1.2 Дээд шатны шүүхэд гомдол гаргах эрхийг сэргээснээр дээд шатны шүүхэд хандсан, шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас болон тусгай хяналтын шатны шүүхэд гомдол гаргах ажиллагааны дагуу шүүхийн шийдвэрээр цагаатгагдсан этгээд нь өмнөх шүүхийн шийдвэрээр хэрэгжүүлсэн ялын улмаас хоригдсон тохиолдолд улсаас хохирол нөхөн төлүүлэхээр шаардах эрхтэй.
- 1.3 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 484-р зүйлээс 486-р зүйл хүртэл заасан баривчлах шийдвэрийн дагуу баривчлагдсан болон тус хуулийн 481-р зүйлийн 2 дахь хэсгийн заалтын дагуу саатуулагдсан тохиолдолд өмнөх заалтад тусгагдсан ял хэрэгжүүлсэнтэй нэгэн адил үзнэ.

Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх хуулийн дагуу хохирол шаардах эрх үүсэхэд дараах хоёр урьдчилсан нөхцөл хангагдсан байх ёстой. Нэгдүгээрт, шүүхээс цагаатгасан шийдвэр гарсан байх; хоёрдугаарт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад баривчлагдсан, хоригдсон байх эсвэл шүүхийн шийдвэрийн дагуу ял эдэлсэн байх юм.<sup>13</sup>

Түүнчлэн сэжигтэн нь саатуулагдаж, баривчлагдсан, цагдан хоригдсон боловч прокурорын зүгээс хэрэг үүсгэлгүй хэргийг хэрэгсэхгүй болгосон тохиолдолд дээр авч үзсэн хууль үйлчлэхгүй

<sup>13</sup> [http://hakusyo1.moj.go.jp/jp/1/nfm/n\\_1\\_2\\_2\\_1\\_5\\_6.html](http://hakusyo1.moj.go.jp/jp/1/nfm/n_1_2_2_1_5_6.html)

боловч Хууль зүйн яамнаас баталсан “Сэжигтний хохирлыг нөхөн төлөх журам”-ын дагуу хохирол шаардах эрхтэй байдаг. Уг журмын 2-р зүйлд “Прокурор нь гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийг яллагдагчаар татаж хэрэг үүсгээгүй тохиолдолд тухайн этгээд гэмт хэрэг үйлдээгүй гэх хангалттай шалтгаан байгаа бол баривчлагдсан, цагдан хоригдсоны хохирлыг нөхөн төлнө”<sup>14</sup> гэж заажээ.

### 1.3.2 ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт

ХБНГУ 1971 онд Хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас үүссэн хохирол нөхөн төлүүлэх тухай хууль *Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG)*-ийг батлан хэрэгжүүлж байна. Уг хуулийн 1-р зүйлд “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас хохирол учирсан этгээд нь тухайн эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон, эсвэл ял оногдуулсан шийдвэрийг хүчингүй болгосон зэрэг бусад байдлаар дуусгавар болгосон тохиолдолд төрийн сангаас хохирол шаардах эрхтэй”<sup>15</sup> гэж хуульчилжээ.

Дээрх 2 улсын зохицуулалтаас үзвэл, хохирол шаардах эрхийн урьдчилсан нөхцөлд “хууль бус” болон “шүүгч, прокурор, мөрдөгч” гэх нэр томъёог хэрэглэлгүйгээр “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх” гэж томъёолж буй нь энгийн ойлгомжтой бөгөөд уг тогтолцооны зорилгод нийцэж буй юм.

<sup>14</sup> 被疑者補償規程（法務省訓令）<http://www.kensatsu.go.jp/content/000127550.pdf>

<sup>15</sup> Gesetz über die Entschädigung für Strafverfolgungsmaßnahmen (StrEG) <https://www.gesetze-im-internet.de/streg/BJNR001570971.html>

## Хоёр. ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ ШААРДАХ ЭРХИЙН ҮНДЭСЛЭЛ

### 2.1. АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг шаардах эрхийн үндэслэл нь аль хуулийн зохицуулалт байх вэ? гэсэн асуулт гарч ирж байна. Өөрөөр хэлбэл, шаардах эрхийн үндэслэл нь Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.4 дэх хэсэг байх уу?, эсвэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэг байх уу? гэсэн асуулт юм.

№	Иргэний хууль	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
1	§498.4. Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг мөрдөгч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана	§45.1 дүгээр зүйл. Хохирол арилгуулах эрх 1. Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй (Энэ хэсэгт 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан.)

*(Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан).*

§45.2 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлүүлэх үндэслэл

1. Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана (*Энэ хэсгийг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан.*).

Энэ төрлийн хэрэгтэй холбоотой шүүхийн шийдвэрүүдийг авч үзвэл, Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.4 дэх хэсгийг шаардах эрхийн үндэслэл болгодог практик тогтжээ. Судлаачдын зүгээс энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсгийг шаардах эрхийн үндэслэл болгож хэрэглэх ёстой гэж үзэж байна.

Учир нь Иргэний хуулийн 3-р зүйлийн 3.3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиас бусад хууль хоорондоо зөрчилдвөл тухайн асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хуулийн, тийм хууль байхгүй бол сүүлд хүчин төгөлдөр болсон хуулийн заалтыг хэрэглэнэ” гэж заасны дагуу асуудлыг илүү нарийвчлан зохицуулсан хууль болох Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтыг шаардах эрхийн үндэслэл болгох хэрэгтэй. 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулга нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан бөгөөд Иргэний хуулийн зохицуулалтын агуулгаас дэлгэрэнгүй болжээ. Тухайлбал, дээрх хүснэгтэд харуулснаар Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.4 дэх хэсэг “хохирол” гэсэн ерөнхий нэг л нэр томьёо хэрэглэсэн байхад, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэгт

“...эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх...” гэж хохирол гэдэгт юу хамаарах талаар дэлгэрэнгүй зохицуулсан байх бөгөөд тухайлбал, “сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах” эрхтэй болохыг хуульд тусгайлан зааж өгчээ.

## 2.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР

УДШ-ийн хэрэг шийдвэрлэсэн тогтоолуудыг авч үзвэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсгийг тогтоолынхоо хянавал хэсэгт дурдах төдий өнгөрч энэхүү заалтыг шаардах эрхийн үндэслэлийн хэмжээнд хэрэглэхгүй байгаа учраас уг заалтын ач холбогдол, зорилго хэрэгжихгүй байна.

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан агуулга
1	2020 оны 05 сарын 14 Дугаар 001/ХТ2020/00223 <sup>16</sup>	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор шүүгчийн хууль бус ажиллагаанаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй” гэж заажээ. М.Г-ийг бусдыг залилан мэхэлж, онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдуулж Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газрын 2009 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авсан, улмаар түүнийг уг хэрэгт гэм буруутай гэж үзэн анхан шатны шүүхээс 10 жил 1 сарын хорих ял

<sup>16</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6652/view>

оногдуулсныг, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 874 тоот магадлалаар хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасныг УДШ-ийн 2012 оны 3 дугаар сарын 21-ний 141 тоот тогтоолоор шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг мөрдөн байцаалтад буцаасан байна. Үүний дараа М.Г-т холбогдох хэргийг Баянзүрх дүүргийн прокурорын 2012 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 835 тоот тогтоолоор гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэн хэрэгсэхгүй болгосон нь тогтоогдсон тул М.Г Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д заасан гэм хорын хохирол шаардах эрхтэй. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг төр хариуцан арилгах үүрэгтэй байна.

---

*Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2019 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 101/ШШ2019/00619 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.4, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д тус тус заасныг үндэслэл болгосныг өөрчлөөгүй Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 758 дугаар магадлалыг хянахдаа УДШ тогтоолынхоо тогтоох хэсэгт хэвээр үлдээж шийдвэрлэжээ.*

---

---

2	2020 оны 04 сарын 14 өдөр Дугаар 001/ ХТ2020/ 00176 <sup>17</sup>	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргаж болдог байна. Харин энд заасан эд хөрөнгийн бус хохирлыг гагцхүү эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгч, эрх бүхий албан тушаалтны хууль зөрчсөн ажиллагааны улмаас хохирсон тухайн этгээд буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д заасан субъект шаардах эрхтэй тул Б.Б уг хуулийн зохицуулалтыг үндэслэн шаардлага гаргах эрхгүй, энэ тухай давж заалдах шатны шүүхийн дүгнэлт хуулийн үндэслэлтэй. Нөгөө талаар, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.8 дугаар зүйлийн 7-д “нас барсан этгээдэд учирсан эд хөрөнгийн хохирлыг өв залгамжлагч шаардах эрхтэй” гэж зааснаас үзвэл нас барсан этгээдэд учирсан эдийн бус хохирлыг шаардах эрх өв залгамжлагчид шилжихгүй юм.
---	---	---

---

*Баянгол дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх 2019 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 102/ШШ2019/00552 дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсгүүдэд заасныг үндэслэл болгосныг өөрчлөөгүй Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 739 дугаар магадлалыг хянахдаа УДШ тогтоолынхоо тогтоох хэсэгт хэвээр үлдээж шийдвэрлэжээ.*

---

<sup>17</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanal/6641/view>



- 3 2020 оны 04 сарын 14 Дугаар 001/ХТ2020/00179<sup>18</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор шүүгчийн хууль бус ажиллагаанаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй” гэж заажээ. Б.Р-г, бүлэглэн бусдын эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдуулж Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтсээс 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдөр эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, хувийн баталгаа гаргах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан, улмаар түүнийг уг хэрэгт гэм буруутай гэж үзэн анхан шатны шүүхээс 5 жилийн хорих ял оногдуулсныг, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 34 тоот магадлалаар хэргийг хэрэгсэхгүй болгосон нь тогтоогдсон тул тэрээр Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлийн 1-д заасан гэм хорын хохирол шаардах эрхтэй этгээдэд хамаарна. Иймээс Б.Р Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хохирол гаргуулахаар хүсэлт гаргах эрхтэй, энэ талаарх давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэл бүхий байна. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг төр хариуцан арилгах үүрэгтэй байна.

<sup>18</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6639/view>

---

*Төв аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 151/ШШ2019/00219 дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсгийг үндэслэл болгосныг өөрчлөөгүй Төв аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 223/МА2019/00013 дугаар магадлалыг хянахдаа УДШ тогтоолынхоо тогтоох хэсэгт хууль зүйн үндэслэлийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.*

---

- |   |   |  |
|---|---|--|
| 4 | 2019 оны<br>03 сарын<br>26 Дугаар<br>001/<br>ХТ2019/<br>00441 <sup>19</sup> | Нэхэмжлэгч Н.С нь бусдыг санаатай алсан гэмт хэрэгт сэжиглэгдэн 2008 оны 10 дугаар сарын 24-ний өдрөөс 2009 оны 12 дугаар сарын 9-ний өдөр хүртэл 295 хоног цагдан хоригдсон байх ба Хэнтий аймгийн прокурорын 2010 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 5/111 дүгээр тогтоолоор гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр түүнд холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон нь тогтоогджээ. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д зааснаар бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл (эс үйлдэхүй)-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй бол хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгахаар хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасан. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болсон, цагаатгагдсан этгээдэд гэм хор учирсан явдал нь маргаангүй үйл баримт тул Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1 дэх зохицуулалт тухайн маргаанд хамааралгүй болохыг шүүх анхаараагүй байна. |
|---|---|--|

---

<sup>19</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5929/view>

*Хэнтий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүх 2018 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 156/ШШ2018/00481 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 498 дугаар зүйлийн 498.4-т заасныг үндэслэл болгосныг өөрчлөөгүй Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 226/МА2018/00018 дугаар магадлалыг хянахдаа УДШ тогтоолынхоо тогтоох хэсэгт хууль зүйн үндэслэлийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.*

5	2018 оны 03 сарын 13 Дугаар 001/ ХТ2018/ 00407 <sup>20</sup>	Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т “Хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгана” гэж заасан тул нэхэмжлэгч нь учирсан хохирлыг арилгуулах эрхтэй байна.
---	---	--

*Дархан-Уул аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 1062 дугаар шийдвэрээр Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасныг үндэслэл болгосныг өөрчлөөгүй Дархан-Уул аймгийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 170 дугаар магадлалыг УДШ тогтоолынхоо тогтоох хэсэгт хууль зүйн үндэслэлийг хэвээр үлдээж шийдвэрлэжээ.*

Дээрх хүснэгтээс харвал, УДШ нь тогтоолынхоо хянавал хэсэгт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсгийг дурдаж, тайлбарлаж буй боловч зэрэгцүүлээд Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.4 дэх хэсгийг мөн дурдаж тайлбарлажээ.

Эндээс эхлээд нэг маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт 2 шаардах эрхийг зэрэгцүүлэн хэрэглэж болох уу? гэсэн асуулт гарч ирнэ. Энэ нь иргэний процессын эрх зүйд байж болохгүй алдаа

<sup>20</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanal/4040/view>

бөгөөд нэхэмжлэлийн зүйл болох шаардах эрх нэг маргаанд нэг л байх ёстой. Өөрөөр хэлбэл, нэг шаардах эрхийн үндэслэл нь нэг маргаан гэж тоологддог болно. Иймд эдгээр 2 заалтын аль нэгийг сонгон авч үндэслэл болгон тайлбарлах нь наад захын шаардлага юм.

Цаашлаад анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны магадлалын тогтоох хэсэгт Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасныг үндэслэл болгосныг УДШ-ээс өөрчлөөгүй хэвээр үлдээсэн байна. Тиймээс эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас үүссэн хохирлыг нөхөн төлүүлэх, шаардах эрхийн үндэслэлийг УДШ-ийн зүгээс Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэг гэж тодорхойлж буй нь нотлогдоно.

Дүгнэж үзвэл, УДШ-ийн энэ төрлийн хэрэг маргааныг шийдвэрлэх гол түлхүүр болсон шаардах эрхийн үндэслэлийг зөв тодорхойлж чадахгүй байна. 2017 онд шинэчлэн найруулагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, прокурор, мөрдөгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан тул 2002 оны Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4 дэх хэсэг нь ач холбогдлоо алдсан, хүчингүй болгоход ямар нэгэн асуудал үүсэхгүй заалт юм. Уг төрлийн маргааныг шийдвэрлэх шаардах эрхийн үндэслэл нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэг байна.

## Гурав. ОНЦГОЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРМААР ШИЙДВЭРЛЭХ МАРГААН МӨН ЭСЭХ

### 3.1. АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн нэмэлт, өөрчлөлтөөр 45.9-р зүйлийг нэмсэн байна. Уг зүйлийн агуулга нь “Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ”<sup>21</sup> гэжээ. 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 397-р зүйлийн 397.1 дэх хэсэгт мөн уг төрлийн хэргийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхээр зохицуулсан байжээ.

Эндээс авч үзвэл, 2017 онд хүртэл уг төрлийн маргааныг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэж ирсэн боловч 2020 оны 1 сарын нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болох хүртэл уг төрлийн маргааныг иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны ердийн журмаар, эсвэл онцгой журмаар шийдвэрлэх эсэх нь тодорхойгүй явж иржээ. Өөрөөр хэлбэл, шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хууль батлагдсан 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрөөс 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хүртэл уг төрлийн маргааныг онцгой журмаар шийдвэрлэх тухай заалт ямар ч хуульд байгаагүй.

УДШ-ийн тогтоолуудыг авч үзвэл, 2017 оны шинэ Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулиар энэ төрлийн маргааныг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх талаар тусгаагүй байх үед онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх ёстой гэсэн тайлбарыг хийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаажээ.

---

<sup>21</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020 оны 1 дүгээр сарын 10 өдөр, <https://www.legalinfo.mn/additional/details/3676?lawid=12694>

Хуульд тусгайлан заасан тохиолдолд хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 133-р зүйлд 133.1 дэх хэсэгт онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэргийг жагсаалтын зарчмаар тусгаж өгсөн байдаг. Иймээс хуульд тусгайлан заагаагүй байхад эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх нэхэмжлэлийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэнэ гэж үзсэн нь зохисгүй бөгөөд жагсаалтын зарчмыг хэрэглэж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийг буруу тайлбарлаж буй явдал юм.

### 3.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР

УДШ-ийн зүгээс “Эрүүгийн байцаан шийтгэх 2002 оны хуулийн 397 дугаар зүйлийн 397.1-д хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ гэж заасан байжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуульд ийм зохицуулалт байхгүй байгаа нь тухайн асуудлыг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхгүй байх үндэслэл болохгүй юм” гэж тайлбарлажээ. Гэвч яагаад гэдэг талаар тодорхой тайлбар хийгээгүй байна. Энэхүү УДШ-ийн тайлбар нь онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх хэрэг хуульд тусгайлан заагдсан байх зарчмыг зөрчиж буй юм.

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан дүгнэлт
1	2019 оны 06 сарын 20 Дугаар 001/ХТ2019/00969 <sup>22</sup>	Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т зааснаар учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй байна. Иймд шүүх учирсан гэх гэм хорын асуудлыг хүсэлтээр буюу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ. Хүсэлт гаргаж буй этгээд өөрт учирсан гэм хорын хэмжээг, нотлох баримтыг гаргаж, үндэслэлээ заах үүрэгтэй хэдий ч гэм хорыг ямар хэмжээгээр хангахыг шүүх шийдвэрлэнэ. Иймд хүсэлт гаргагчийн гаргаж өгсөн баримтыг бусад баримттай харьцуулах, нэмж баримт бүрдүүлэх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсгийн зохицуулалтыг зөрчихгүй гэдгийг шүүх шийдвэр гаргахдаа анхаараагүй нь дутагдалтай болжээ. Анхан болон давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан журмыг зөрчсөн, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэргийг эрх зүйн маргаан бүхий нэхэмжлэлтэй хэрэг гэж үзэж, мэтгэлцээний үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсныг хяналтын шатны шүүх тогтоолоор залруулах боломжгүй тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаав.

<sup>22</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6360/view>

- 2 2018 оны 12 сарын 06 Дугаар 001/ХТ2018/01775<sup>23</sup> Шүүх дээрх ажиллагаанаас учирсан гэм хорын асуудлыг эрх зүйн маргааны журмаар буюу нэхэмжлэлээр бус, харин хүсэлтээр буюу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг болно. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болсон, цагаатгагдсан этгээдэд гэм хор учирсан явдал нь маргаангүй хүлээн зөвшөөрөгдөх үйл баримт юм. Нөгөө талаар, уг гэм хор эрх бүхий этгээдийн хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас учирсан байдаг тул Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан үндэслэлээр энэ хэрэгт хариуцагчаар уг үйл ажиллагааг явуулсан этгээд оролцох үндэслэлгүй болно. Харин хүсэлт гаргаж буй нэхэмжлэгч нь өөрт учирсан гэм хорын хэмжээг нотлох үүрэгтэй ба шүүх гэм хорыг хэдий хэмжээгээр хангах эсэхийг шийдвэрлэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх 2002 оны хуулийн 397 дугаар зүйлийн 397.1-д “хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ” гэж заасан байжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуульд ийм зохицуулалт байхгүй байгаа нь тухайн асуудлыг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхгүй байх үндэслэл болохгүй юм. Шүүх нэхэмжлэгч М.С-ийн нэхэмжлэлтэй хэрэгт хариуцагчаар Монгол Улсын Засгийн газрыг татан оролцуулж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1-д заасан эдийн ба эдийн бус баялагтай холбоотой эрх нь зөрчигдсөн тухай эрх зүйн харилцаанд оролцогч этгээдээс гаргасан нэхэмжлэлтэй иргэний хэрэг гэж хэргийг хянан шийдвэрлэсэн нь алдаатай болжээ. Анхан болон давж заалдах шатны шүүх хэрэг хянан

<sup>23</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5344/view>



шийдвэрлэх ажиллагааны хуульд заасан журмыг зөрчсөн, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх хэргийг эрх зүйн маргаан бүхий нэхэмжлэлтэй хэрэг гэж үзэж, мэтгэлцээний үндсэн дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсныг хяналтын шатны шүүх тогтоолоор залруулах боломжгүй тул шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хянан хэлэлцүүлэхээр буцаахаар шийдвэрлэв.

- |   |  |   |
|---|--|---|
| 3 | 2018 оны 05 сарын 04 Дугаар 001/ХТ2018/00717 <sup>24</sup> | 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 397 дугаар зүйлийн 397.1 дэх хэсэгт хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх тухай заасан байсан нь уг хууль хүчингүй болсноор хуулийн зохицуулалтгүй болсон, 2017 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд энэ талаар зохицуулаагүй нь хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхгүй гэх үр дагаврыг бий болгоогүй юм. Иргэний хуулийн 498 дугаар зүйлээс үүдэн гэм буруутай эсэхээс үл хамаарч, иргэний эрх нь зөрчигдсөн болохыг сэргээсэн учраас хохирлыг арилгуулах үндэс болсон гэм буруугийн талаар маргах, мэтгэлцэх шаардлагагүй тул хэргийг онцгой ажиллагааны журмаар хэргийг шийдвэрлэнэ. Онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх хэрэгт мэтгэлцэх зарчим хамаарахгүй гэсэн нь нэхэмжлэлийг хангах үндэслэл болохгүй бөгөөд нэхэмжлэлийн шаардлага үндэслэлтэй эсэх, нотлогдсон эсэх асуудлаар шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу хууль зүйн дүгнэлт өгч, шийдвэр гаргах юм. |
|---|--|---|

<sup>24</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/4269/view>

---

4	2018 оны 03 сарын 13 Дугаар 001/ ХТ2018/ 00411 <sup>25</sup>	Шүүх дээрх ажиллагаанаас учирсан гэм хорын асуудлыг эрх зүйн маргааны журмаар буюу нэхэмжлэлээр бус, харин хүсэлтээр буюу онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэдэг болно. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болсон, цагаатгагдсан этгээдэд гэм хор учирсан явдал нь маргаангүй хүлээн зөвшөөрөгдөх үйл баримт юм. Нөгөө талаар, уг гэм хор эрх бүхий этгээдийн хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас учирсан байдаг тул Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1-д заасан үндэслэлээр энэ хэрэгт хариуцагчаар уг үйл ажиллагааг явуулсан этгээд оролцох үндэслэлгүй болно. Харин хүсэлт гаргаж буй нэхэмжлэгч нь өөрт учирсан гэм хорын хэмжээг нотлох үүрэгтэй ба шүүх гэм хорыг хэдий хэмжээгээр хангах эсэхийг шийдвэрлэнэ. Эрүүгийн байцаан шийтгэх 2002 оны хуулийн 397 дугаар зүйлийн 397.1-д “хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай өргөдлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ” гэж заасан байжээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуульд ийм зохицуулалт байхгүй байгаа нь тухайн асуудлыг онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэхгүй байх үндэслэл болохгүй юм.
---	--	--

---

УДШ уг төрлийн маргааныг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх ёстой гэж үзэхдээ “эрүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болсон, түүнчлэн цагаатгагдсан этгээдэд гэм хор учирсан явдал нь маргаангүй үйл баримтад хамаарах тул дээрх ажиллагаанаас учирсан гэм хорыг нэхэмжлэгчийн хүсэлтээр онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэгдэг” гэжээ. Маргаангүй үйл баримт учраас онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэгдэх ёстой гэж буй нь мөн учир дутагдалтай тул судлаачдын зүгээс санал нийлэхгүй байна.

<sup>25</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3844/view>

Маргаангүй үйл баримт гэдэгт юуг хамааруулах талаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тодорхой хуульчилсан байдаг. Уг хуулийн 40-р зүйлийн 40.4 дэх хэсэгт “Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон буюу нийтэд илэрхий үйл баримт хэрэг хянан шийдвэрлэхэд холбогдолтой байвал түүнийг дахин нотлохгүй” гэж зааснаас авч үзвэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон үйл баримтыг маргаангүй үйл баримт гэж үзэхээр байна.

Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 45.2-р зүйлийн 2 дахь хэсэгт хохирол нөхөн төлүүлэх эрх үүсэх урьдчилсан нөхцөлийг хуульчилсан. Үүнд:

- хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн нь тогтоогдсон;
- тухайн хүнийг цагаатгасан шүүхийн шийдвэр гарсан;
- тухайн хэрэг нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон;
- эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон;
- яллагдагчийг эрүүдэн шүүсэн болох нь нотлогдсон.

Тухайлбал, прокурорын хяналтын шатанд “гэмт хэргийн шинжгүй, эсхүл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон” тохиолдолд шүүхийн шийдвэрээр тогтоогдож буй үйл баримт биш тул маргаангүй үйл баримт гэх үзэхгүй. Цаашлаад “тухайн хүнийг цагаатгасан шүүхийн шийдвэр гарсан” гэдэг нь хохирол шаардах эрхийн нэг л урьдчилсан нөхцөл тодорхой болж буй бөгөөд бусад урьдчилсан нөхцөл дээр мэтгэлцээн өрнөх боломж нээлттэй юм. Иймд бүхий л тохиолдолд маргаангүй үйл баримт байгаа мэтээр тайлбарлан онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх ёстой гэж үзэх нь зохисгүй юм. Нөгөө талаас, маргаангүй үйл баримттай хэргийг л онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэдэг гэсэн ойлголт бас хаана ч байхгүй билээ. Өөрөөр хэлбэл, хуулийг үндэслэл бүхий байдлаар тайлбарлаж хэрэглээгүй байна.

## Дөрөв. ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА АВАХАД ТӨЛСӨН ХӨЛСИЙГ НӨХӨН ТӨЛҮҮЛЭХ

### 4.1. АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 45.3-р зүйлийн 1 дэх хэсгийн 1.6 дахь заалтад “хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлс”-ийг эд хөрөнгийн хохиролд хамааруулан хуульчилсан байна.

УДШ-ийн тогтоолуудыг авч үзвэл, хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг нөхөн төлүүлж байгаа байдал ажиглагдаж байгаа боловч хууль зүйн туслалцаа авахдаа хөлс төлсөн гэдгийг авч үзэхдээ харилцан адилгүй байдлаар үйл баримтыг үнэлсэн нь анхаарал татаж буй асуудал юм.

### 4.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан дүгнэлт
1	2020 оны 05 сарын 14 Дугаар 001/ХТ2020/00223 <sup>26</sup>	...хууль зүйн туслалцаа үзүүлэх хөлс 7,013,000 төгрөг гэж тодорхойлжээ... Хууль бус ажиллагааны улмаас эд хөрөнгөнд учирсан хохиролд хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлс хамаарах бөгөөд нэхэмжлэгч М.Г хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд өмгөөлөгч авч 2,000,000 төгрөгийн хөлс төлсөн нь тогтоогдсон байх тул нэхэмжлэлийн энэ шаардлагыг хангасан нь хуулийн үндэслэлтэй байна.

<sup>26</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6652/view>

2	2020 оны 04 сарын 14 Дугаар 001/ ХТ2020/ 00179 <sup>27</sup>	...өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авахад төлсөн 7,500,000 төгрөг гэж тодорхойлжээ. Хууль бус ажиллагааны улмаас эд хөрөнгөд учирсан хохиролд хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлс хамаарах бөгөөд нэхэмжлэгч Б.Р хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагааны явцад болон шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шатанд гэрээний үндсэн дээр өмгөөлөгч авч 7,500,000 төгрөгийн хөлс төлсөн нь тогтоогдсон байх тул давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн энэ шаардлагыг бүхэлд нь хангасан нь хуулийн үндэслэлтэй байна.
3	2019 оны 01 сарын 24 Дугаар 001/ ХТ2019/ 00117 <sup>28</sup>	О.С-ыг эрүүгийн хэрэгт шалгагдаж байх үед түүний эх А.Оюунцэцэг өмгөөлөгч М.Төмөрцэцэгтэй “Хууль зүйн туслалцаа үзүүлэх” гэрээ байгуулж, хөлсөнд 10,000,000 төгрөг төлөхөөс 5,000,000 төгрөгийг гэрээ байгуулсан даруйд төлөхөөр тохиролцсон. Нэхэмжлэгч 2014 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс 2014 оны 6 дугаар сарын 26-ны өдөр цагдан хоригдсон нь болон уг хугацаанд өмгөөлөгч Хорих 461 дүгээр ангид удаа дараа очиж уулзсан нь хэргийн баримтаар тогтоогдсон байна. ...Хууль бус ажиллагааны улмаас эд хөрөнгөд учирсан хохиролд хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлс хамаарах бөгөөд өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсоныг үгүйсгэх боломжгүй тул 5,000,000 төгрөгийн хэмжээнд нэхэмжлэлийг хангахад хууль зөрчихгүй байна. Харин О.С нь өмгөөлөгч М.Төмөрцэцэгт эрүүгийн хэрэгт шалгагдах үедээ нэмж 5,000,000 төгрөг, иргэний хэрэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад 4,500,000 төгрөг тус тус төлснөө хангалттай нотлоогүй байна.

<sup>27</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6639/view>

<sup>28</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5566/view>

---

4	2019 оны 01 сарын 10 Дугаар 001/ ХТ2019/ 00036 <sup>29</sup>	Шүүх өмгөөлөгчийн зардалд 50,000,000 төгрөг гаргуулах хүсэлтийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон нь дутагдалтай болжээ. Хэргийн 10 дугаар талд буй баримт М.Б нь 40,500,000 төгрөг өмгөөлөгчид төлснийг нотлохгүй байх тул энэ талаар шүүх зөв дүгнэлт хийсэн байна. Харин “Өмгөөллийн эрх зүйн туслалцаа үзүүлэх” 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн гэрээний 4-ийн 2-т өмгөөлөгчийн зардлын урьдчилгааг бэлнээр төлөхөөр талууд тохиролцсон, өмгөөлөгч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх шат шатны ажиллагаанд оролцсон нь тогтоогдож байх тул 50,000,000 төгрөгийн шаардлагаас 9,500,000 төгрөгийг гаргуулах нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.3-р зүйлийн 1.6-г зөрчихгүй гэж үзлээ.
5	2017 оны 03 сарын 09 Дугаар 001/ ХТ2017/ 00250 <sup>30</sup>	Нэхэмжлэгч С.Цэцгээ эрүүгийн хэрэгт холбогдон шалгагдаж, хууль зүйн туслалцаа авах гэрээг өмгөөлөгч А.Серикжан, С.Нургайып нартай 2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр байгуулсан. Уг гэрээгээр тохиролцсоны дагуу өмгөөлөгч нар С.Цэцгээд холбогдох эрүүгийн 201404000315 тоот хэргийн анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд оролцсон нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон байна. Анхан шатны шүүх нэхэмжлэгчийн өмгөөллийн хөлс гаргуулах нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгохдоо “...нэхэмжлэгчээс иргэний хэрэгт гаргаж өгсөн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, эрүүгийн хэрэг шалгах явцад тухайн хэрэгт өгсөн гэрээ хоорондоо зөрүүтэй, өмгөөллийн хөлсийг нөхөрлөлийн дансанд хийгээгүй, хөлс төлсөн баримт эргэлзээтэй...” гэсэн дүгнэлт хийснийг давж заалдах шатны шүүх үндэслэлтэй гэж үзсэн

---

<sup>29</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5546/view>

<sup>30</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/2253/view>

нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, 38 дугаар зүйлийн 38.1-д заасантай нийцээгүй байна. Иргэний хэрэгт нотлох баримтаар өгсөн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ, эрүүгийн хэргээс хуулбарлан авсан гэрээнээс Өмгөөллийн Өлгий адвокат ХНН-ийн тамга дарагдсан, “тайлбар, өмгөөллийн хөлсний урьдчилгаа 2,000,000 төгрөгийг бэлнээр хүлээн авлаа” гэх бичиглэлээр өөр байгаа хэдий ч эдгээр 2 гэрээний огноо, дугаар, бичиглэл адил байх ба уг баримтууд нэг нэгийгээ үгүйсгэх баримт биш байна. Үүнээс гадна өмгөөлөгчийн хөлсөнд бэлнээр 2,000,000 төгрөг, 2,000,000 төгрөгт тооцож мал хүлээлгэн өгсөн гэх гэрээний талуудын үйлдсэн мөнгөний баримтыг эргэлзээтэй гэх үндэслэлгүй. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасан “өмгөөллийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээд ажлын байртай, банканд харилцах данстай байна” гэснийг зөрчиж Өмгөөллийн Өлгий адвокат ХНН нь өмгөөллийн хөлсийг дансанд хийгээгүй гэж дүгнэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлгүй, тухайн өмгөөллийн нөхөрлөлийн үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх нь нэхэмжлэгч С.Цэцгээгийн хувьд хамааралгүй болно. Дээрх алдааг давж заалдах шатны шүүх илрүүлж засаагүй нь буруу болжээ.

---

6	2016 оны 10 сарын 21 Дугаар 001/ ХТ2016/ 01079 <sup>31</sup>	Баян-Өлгий аймаг дахь сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 279 дүгээр шийдвэрээр Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасныг баримтлан Монгол Улсын Засгийн Газрын нөөц сангаас эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад мөрдөн байцаагч,
---	--	---

---

<sup>31</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/1667/view>

прокурорын хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирол 4,000,000 төгрөгийг гаргуулахыг хүссэн нэхэмжлэгч Ожых овогт Абилхайрын Мейрамханы нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.9-д зааснаар энэхүү нэхэмжлэл нь улсын тэмдэгтийн хураамж төлөхөөс чөлөөлөгдсөн болохыг дурдаж шийдвэрлэжээ. Хоёр шатны шүүх А.М-ны хүсэлтийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг зөрчөөгүй байх ба хэрэгт цугларсан баримтыг харьцуулан ач холбогдолтой, эргэлзээгүй талаас нь үнэлж, хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон нь зөв боловч хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүйг магадлалд өөрчлөлт оруулах замаар зөвтгөх боломжтой гэж үзэв. А.Мейрамхан нь өмгөөлөгчийн хөлс 3,000,000, сэтгэл санааны хохирол 1,000,000, нийт 4,000,000 төгрөг гаргуулах шаардлагаа хууль бусаар гэмт хэрэгт шалгагдаж, таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан гэх үйл явдалд үндэслэжээ. ...Өмгөөлөгчийн зардлын талаарх эргэлзээтэй баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй юм.

Дээрх хүснэгтэд дурдаж буй УДШ-ийн тогтоолуудаас эхний 2 тохиолдолд төлбөр төлсөн гэх үйл баримтыг тогтоож байж сая хохирол тооцон нөхөн төлүүлсэн байна. Харин 3, 4, 5 дахь тохиолдлыг авч үзвэл, шууд бус үйл баримтад тулгуурлан хууль зүйн туслалцаа авахдаа төлбөр төлсөн болохыг тогтоожээ. Тухайлбал 3 дахь тохиолдолд “өмгөөлөгч М.Төмөрцэцэгтэй “Хууль зүйн туслалцаа үзүүлэх” гэрээ байгуулж, хөлсөнд 10,000,000 төгрөг төлөхөөс 5,000,000 төгрөгийг гэрээ байгуулсан даруйд төлөхөөр тохиролцсон, нэхэмжлэгч 2014 оны 5 дугаар сарын 9-ний өдрөөс 2014 оны 6 дугаар сарын 26-ны өдөр цагдан хоригдсон нь болон уг хугацаанд өмгөөлөгч Хорих 461 дүгээр



ангид удаа дараа очиж уулзсан нь хэргийн баримтаар тогтоогдсон байна” гэснээс өмгөөлөгчтэй хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан урьдчилгаа өгөхөөр тохирсон, өмгөөлөгч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцон хууль зүйн туслалцаа үзүүлсэн гэсэн 2 шууд бус үйл баримтад тулгуурлан хохирлыг нөхөн төлүүлэхээр хангаж шийдвэрлэжээ.

Гэвч 6 дахь тохиолдлыг авч үзвэл, хүсэлт гаргагчийн өмгөөлөгч хяналтын гомдолдоо “А.М эрүүгийн хэрэгт шалгагдаж байхдаа өмгөөлөгч сонгон авсан нь 2013 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн “Эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ”-ээр нотолж, гэрээний 3.1-д “хөлсөнд 3,000,000 төгрөг”, 3.2-т үүнээс урьдчилгаанд 1,000,000 төгрөгийг гэрээ байгуулан бэлэн төлөхөөр талууд тохиролцсон. Эрүүгийн хэрэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээний өмгөөллийн хөлс нь сэжигтэн, яллагдагчийн хувьд нууц байх нь зохимжтой гэж үздэг учраас мөрдөн байцаагчид хүргүүлсэн гэрээний нэг хувьд өмгөөллийн хөлсний талаар “Тохиролцсон” гэж бичигддэг юм. Практикт өмгөөллийн хөлсийг үйлчлүүлэгч нар ихэвчлэн бэлнээр төлдөг. Яллагдагч А.М нь өмгөөллийн хөлсөнд 2013 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 1,000,000, 2015 оны 10 дугаар сарын 28-ны өдөр 2,000,000, нийт 3,000,000 төгрөг тус тус төлсөн. Гэтэл анхан шатны шүүх өмгөөллийн хөлс авсан тасалбарууд эрүүгийн хавтаст хэрэгт авагдаагүй, эргэлзээтэй байна гэж буруутгасан нь хууль зүйн үндэслэл муутай байна. Мөнгө хүлээлгэж өгөх, хүлээн авах нь зөвхөн үйлчлүүлэгч, өмгөөлөгчийн хооронд явагддаг хувийн асуудал тул бусад иргэд, байгууллага хөндлөнгөөс оролцох ёсгүй” гэжээ.

Хэрвээ 3, 4, 5 дахь тохиолдолтой адил шууд бус үйл баримтад тулгуурласан бол энэ тохиолдолд ч мөн өмгөөллийн хөлс авах эрхийг хангаж шийдвэрлэх ёстой.

## Тав. ОЛОХ ЁСТОЙ БАЙСАН ОРЛОГЫГ ТООЦОХ

### 5.1. АСУУДАЛ

Эрүүгийн хэрэг хянан шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.3-р зүйлийн 1 дэх хэсгийн 1.1 дэх заалтад “хууль бус ажиллагааны улмаас хүний аваагүй цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлого”-ыг эд хөрөнгийн хохиролд хамруулж нөхөн төлүүлэхээр хуульчилжээ.

УДШ-ийн тогтоолуудыг авч үзэхэд, уг хохирлыг тооцохдоо гэм хор учирсан үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, эсвэл хэрэг хянан шийдвэрлэж буй үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлах зэрэг ялгаатай байдлаар шийдвэрлэсэн, мөн хохирол учирсан хугацааг тооцохдоо ялгаатай байдлаар шийдвэрлэжээ.

### 5.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Эхлээд хууль бус ажиллагааны улмаас хүний аваагүй цалин хөлс, олох байсан орлогыг аль үеийн үнэлэмжээр тооцох талаар харилцан адилгүй шийдвэр гаргаж байгааг авч үзье.

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан дүгнэлт
1	2020 оны 05 сарын 14 Дугаар 001/ХТ2020/00223 <sup>32</sup>	М.Г-ийг бусдыг залилан мэхэлж, онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдуулж Нийслэлийн Баянзүрх дүүргийн прокурорын газрын 2009 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн тогтоолоор эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, хувийн баталгаа гаргах таслан сэргийлэх арга хэмжээ авсан.

<sup>32</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6652/view>

Улмаар түүнийг уг хэрэгт гэм буруутай гэж үзэн анхан шатны шүүхээс 10 жил 1 сарын хорих ял оногдуулсныг, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2011 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 874 тоот магадлалаар хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгасныг Улсын Дээд шүүхийн 2012 оны 3 дугаар сарын 21-ний 141 тоот тогтоолоор шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, хэргийг мөрдөн байцаалтад буцаасан байна. Үүний дараа М.Г-т холбогдох хэргийг Баянзүрх дүүргийн прокурорын 2012 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 835 тоот тогтоолоор гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэн хэрэгсэхгүй болгосон. ...цагдан хоригдсон 78 хоногийг 24 цагт шилжүүлж, нийт 1,872 цагийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ болох 320,000 төгрөг (Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт үндэсний хорооны 2018 оны 8 дугаар сарын 19-ний өдрийн 05 тоот тогтоолын дагуу баталсан 1 цагт 1, 904.76 төгрөг)-өөр тооцож, 3,565,710 төгрөг олгохоор шийдвэрлэсэн нь ажил, хөдөлмөр эрхлээгүйн улмаас олох байсан орлогоо алдсантай холбоотой хохиролд тооцогдох тул зөв.

2	2019 оны 01 сарын 15 Дугаар 001/ ХТ2019/ 00057 <sup>33</sup>	Анхан шатны шүүх Монгол Улсын Засгийн газраас “...нийт 488 хоногийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 140,400 төгрөгийг нэг сард ногдох ажлын 21.5 хоногт тооцон 3,186,640 төгрөг, өмгөөлөгчийн хөлс 3,000,000 төгрөг, сэтгэл санааны хохирол 50,000,000 төгрөг нийт 56,186,640 төгрөг...” гаргуулахаар шийдвэрлэснийг, давж заалдах шатны шүүх хянаж 50,000,000 төгрөгийг хасаж, шийдвэрт өөрчлөлт оруулсан байна. Б.Б-гийн төлөөлөгч анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээхийг хүссэн тул тус шүүхээс хяналтын
---	--	--

<sup>33</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanal/5540/view>

гомдлын хүрээнд буюу “...сэтгэл санааны хохиролд 50,000,000 төгрөг гаргуулах үндэслэлтэй...” эсэх талаар дүгнэлт хийнэ. Дорнод аймгийн Цагдаагийн газраас Б.Б-д эрүүгийн хэрэг үүсгэн 2012 оны 2 дугаар сарын 14-ний өдөр сэжигтнээр тооцож, 2012 оны 2 дугаар сарын 16-ны өдрөөс сэжигтнээр, 2012 оны 2 дугаар сарын 28-ны өдрөөс яллагдагчаар 2013 оны 6 дугаар сарын 6-ны өдөр хүртэл нийт 488 хоног цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан нь, мөн Дорнод аймаг дахь Сум дундын 10 дугаар шүүхийн 2014 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 58 дугаар тогтоолоор цагаатгасан нь тус тус тогтоогдсон байна.

---

3	2018 оны 12 сарын 04 Дугаар 001/ ХТ2018/ 01759 <sup>34</sup>	Хэрэгт авагдсан баримтаас үзэхэд О нийт 134 хоног цагдан хоригдсон, эрүүгийн хэрэгт сэжигтнээр шалгаж эхлэх үед ажил эрхэлж байсан боловч цалин хөлсний хэмжээг нь тодорхойлох боломжгүй гэж анхан шатны шүүх дүгнэж, түүний цагдан хоригдсон хоногийн нөхөн төлбөрийг хоригдож байсан үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр нэг сарын хугацааг тооцож, нийт 73,218 төгрөг олгосныг буруутгах үндэслэл тогтоогдохгүй байна. Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрт өөрчлөлт оруулахдаа хүсэлтийн агуулгыг хэрэгт авагдсан баримттай харьцуулан үнэлж чадаагүй, түүнчлэн О гийн хууль бусаар цагдан хоригдсон 134 хоногт Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооноос тогтоосон одоо мөрдөж буй хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 240,000 төгрөгөөр тооцож 960,000 төгрөгөөр тооцсон нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 40 дүгээр зүйлийн
---	--	---

<sup>34</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5338/view>

40.1, 40.2-т нийцээгүй байна. Иймд О болон түүний өмгөөлөгчийн гомдлыг хангаж, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоов.


4	2018 оны 03 сарын 13 Дугаар 001/ ХТ2018/ 00407 <sup>35</sup>	Хорих ял эдэлж байх үед мөрдөгдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тус тус харгалзан, ажлын 21.5-д хуваахад нэг өдрийн хөлсний хэмжээ гарах бөгөөд үүнийг хоригдсон хугацаагаар тооцоход нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд 4,128,000 төгрөгийг гаргуулах үндэслэлтэй байна.
5	2018 оны 02 сарын 02 Дугаар 001/ ХТ2018/ 00169 <sup>36</sup>	Харин нэхэмжлэгч нар сэтгэл санааны хохирлын хэмжээг нэхэмжлэлдээ 4,000 төгрөг (цагдан хоригдоогүй таслан сэргийлэх арга хэмжээтэй байх үед) гэж заахдаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг өдөрт тооцох жишгээр тогтоосон гэж тайлбарласнаас үзвэл тухайн гэм хорын агуулга нь эд хөрөнгийн шинжтэй гэж үзэхээр байна. Энэ утгаар нэхэмжлэгч нарын шаардлагыг дараах байдлаар хангах боломжтой гэж үзэв: Д.И-ийн цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн 186 хоногт оногдох цалин хөлсийг 2011 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 2012 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хүртэл тооцон 1,235,000 төгрөг; нотлох баримт бүрдүүлэх зардалд 47,500 төгрөг; өмгөөлөгчид төлсөн нийт хөлс 5,200,000 төгрөг; Д.И-ийн таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тус тус тооцон 3,627,000 төгрөг; Б.Э-ын таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нэг хоногт 4,000 төгрөгөөр тооцон 5,580,000 төгрөг.

<sup>35</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/4040/view>

<sup>36</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3809/view>

Дээрх тохиолдлуудаас харвал, 1 дэх тохиолдолд 2012 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 835 тоот тогтоолоор гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэн хэрэгсэхгүй болгосон байхад олох ёстой байсан орлогыг тооцохдоо анхан шатны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байх үед мөрдөгдөж байсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр хохирлыг тооцон үнэлжээ.

Харин бусад тогтоолд нэхэмжлэгч цагдан хоригдсон, эсвэл хорих ял эдэлж байсан үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр хохирлыг тооцжээ.



Ийнхүү харилцан адилгүй байдлаар хохирлыг тодорхойлж буй нь буруу юм. Иргэний хуулиар хохирлыг тодорхойлохдоо гэм хор учирсан үеийн үнэлэмжийг баримталдаг. Тухайлбал, Иргэний хуулийн 505-р зүйлийг 505.2 дахь хэсэгт “Гэм хор учруулах үед хохирогч цалин хөлс, орлогогүй байсан бол тэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй хэмжээний нөхөн төлбөр шаардах эрхтэй” гэж зааснаас энэ зарчмыг харж болно.

Иймээс гэм хор учирсан үеийн бус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлах нь Иргэний хуулийг зөрчсөн хэрэг билээ. Үүнээс гадна хууль

бус ажиллагааны улмаас хүний аваагүй цалин хөлс, олох байсан орлогыг тооцох хугацааг мөн ялгаатай байдлаар авч үзсэн УДШ-ийн тогтоолуудыг авч үзье. Өмнөх хүснэгтэд харуулсан тохиолдлуудад цагдан хоригдсон, эсвэл хорих ял эдэлсэн хугацааг хохирол учирсан хугацаа гэж үзэж байсан бол дараах 2 тохиолдолд хохирол учирсан хугацааг өөрөөр авч үзсэн байна.

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан дүгнэлт
1	2020 оны 04 сарын 14 Дугаар 001/ХТ2020/00179 <sup>37</sup>	<p>Б.Р-г бүлэглэн бусдын эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулсан гэмт хэрэгт холбогдуулж Нийслэлийн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 3-р хэлтсээс 2017 оны 8 дугаар сарын 22-ны өдөр эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, хувийн баталгаа гаргах, таслан сэргийлэх арга хэмжээ авсан. Улмаар түүнийг уг хэрэгт гэм буруутай гэж үзэн анхан шатны шүүхээс 5 жилийн хорих ял оногдуулсныг, Нийслэлийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 34 тоот магадлалаар хэргийг хэрэгсэхгүй болгосон нь тогтоогдсон. Амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн орлого эд хөрөнгөд учирсан хохирол мөн учир давж заалдах шатны шүүх орлогыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцохоор дүгнэлт хийсэн нь үндэслэлтэй хэдий ч хугацааг Б.Р-ийн эрүүгийн хэрэгт шалгагдан яллагдагчаар татагдсанаар бус зөвхөн цагдан хоригдсон 78 хоногоор тодорхойлсныг өөрчилж, 2017 оны 8 дугаар сарын 22-оос 2017 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүртэл 2 сар, 3 хоногийн орлогод 504,000 төгрөгийг нэмж, нийт 1,104,000 төгрөг гаргуулах нь хууль зөрчихгүй бөгөөд нэхэмжлэлийн үндэслэл, шаардлагын хэмжээнд гэж үзнэ. Энэ үндэслэлээр магадлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.</p>

<sup>37</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6639/view>

- 
- 2 2019 оны 01 сарын 24 Дугаар 001/ХТ2019/00117<sup>38</sup> О.С эрүүгийн гэмт хэрэгт шалгагдан, энэ хугацаанд 50 хоног цагдан хоригдсон, улмаар Дүүргийн нэгдүгээр прокурорын газрын 2015 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 1152 дугаар тогтоолоор түүнд холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон нь тогтоогдсон байна. О.С-ын олох байсан орлогод 22,000,000 төгрөг гаргуулах нэхэмжлэлээс анхан шатны шүүх цагдан хоригдсон 50 хоногийн хугацаагаар хохирлыг тооцон гаргуулсан нь учир дутагдалтай байна. Эд хөрөнгөд учирсан хохиролд амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн орлого хамаардаг ба хоёр шатны шүүх нэхэмжлэгчийн орлогыг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон гаргуулсан нь зөв боловч хугацааг эрүүгийн хэрэгт шалгагдсанаар бус зөвхөн цагдан хоригдсон хоногоор тооцсон нь хуульд нийцэхгүй байна. Нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн энэ тухай гомдлыг хангаж, олох байсан орлогод нийт 3,113,729 төгрөгийг гаргуулах нь үндэслэлтэй гэж үзлээ.
- 

Дээрх хүснэгтээс харахад, эхний тохиолдолд цагдан хоригдсон хугацааг бус яллагдагчаар татагдсан үеэс хохирол учирсан хугацааг тоолсон бол, дараагийн тохиолдолд эрүүгийн хэрэгт шалгагдсан хугацааг хохирол учирсан хугацаа гэж үзжээ. Ийнхүү ялгаатай байдлаар шийдвэрлэж буй нь хохирол учирсан хугацааг хэдий үеэс эхлэн тоолох талаар хууль хэрэглээ төлөвшөөгүй байгааг харуулж байна.

Бусад улсын жишгийг авч үзэхэд ял эдлүүлсэн, саатуулагдсан, баривчлагдсан, цагдан хоригдсон зэрэг эрх чөлөө нь хязгаарлагдсан хугацааг хохирол учирсан хугацаанд тооцдог байна. Тухайлбал, Япон Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлөх хуулийн 4-р зүйлд “Баривчлагдсан эсвэл цагдан хоригдсоны улмаас үүссэн хохирлыг хоногоор тоолон нэг хоногт нэг

<sup>38</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5566/view>



мянгаас арван хоёр мянга таван зуун иен хүртэл хэмжээгээр нөхөн төлбөр олгоно. Хорих ял эдэлсэн тохиолдолд нэгэн адил байна”<sup>39</sup> гэж хуульчилжээ.

Эндээс үзвэл баривчлагдсан, цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн хугацааг хохирол учирсан хугацаа гэж үзэх нь зөв юм. Харин байцаалт, мэдүүлэг өгсөн гэх мэт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсоны улмаас алдсан, олох ёстой байсан орлогоо нэмэлтээр шаардах боломж нээлттэй.

---

<sup>39</sup> 刑事補償法 [https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws\\_search/lsg0500/detail?lawId=325A C0000000001](https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=325A C0000000001)

## Зургаа. СЭТГЭЛ САНААНЫ ГЭМ ХОРЫГ АРИЛГАХ

### 6.1. АСУУДАЛ

Дүн шинжилгээ хийсэн нийт хэргийн дийлэнх хувьд нь сэтгэл санааны хохирол нэхэмжилжээ. УДШ-ийн зүгээс “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т зааснаар гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө. Сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөөр төлөх талаар хуульд тусгайлан заагаагүй тул хяналтын гомдлыг хангах үндэслэлгүй байна” гэж тайлбарлажээ.

Хэдий тийм боловч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан ...сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах ... эрхтэй” гэж заан сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах эрхтэй болохыг уг хуульд тусгайлан заасан байхад дээрх тайлбарыг УДШ-ээс хийж буй нь анхаарал татаж буй асуудал юм.

### 6.2. ШҮҮХИЙН ШИЙДВЭР

#### 6.2.1 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-р зүйлийн 1 дэх хэсэг материаллаг эрх зүй хэм хэмжээ болох нь

УДШ-ийн зүгээс Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-р зүйлийн 1 дэх хэсгийг процессын эрх зүйн хэм хэмжээ гэж тайлбарласан байна. Цаашлаад “эдийн бус гэм хорын хохирол гаргуулахаар шүүхэд хандах эрхтэйг журамласан явдал нь тухайн нэхэмжлэлийг хангах хууль зүйн үндэслэл болохгүй” гэж үзсэн байна. Өөрөөр хэлбэл, шүүх сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагатай нэхэмжлэлийг хүлээн авах боловч ямар ч тохиолдолд нэхэмжлэлийг хангахгүй гэж хэлж байгаа нь төсөөлөхөд бэрх логик алдаа юм. Уг нь нэхэмжлэл гаргах эрхтэй гэдэг үгийн агуулгад шаардах эрх багтаж байдаг билээ.

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан дүгнэлт
1	2020 оны 05 сарын 14 Дугаар 001/ХТ2020/00223 <sup>40</sup>	Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан ба мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагаанаас учирсан сэтгэл санааны хохирлыг гаргуулах, үнэлэх талаар хуульд тусгайлан заагаагүй тул хохирол гаргуулах боломжгүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлийн 1-д болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д эдийн бус гэм хорын хохирол гаргуулахаар шүүхэд хандах эрхтэйг журамласан явдал нь тухайн нэхэмжлэлийг хангах хууль зүйн үндэслэл болохгүй юм.
2	2019 оны 01 сарын 10 Дугаар 001/ХТ2019/00036 <sup>41</sup>	Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4, 230 дугаар зүйлийн 230.2-т зааснаар хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг төр хариуцах бөгөөд гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө. Эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх талаар хуульд тусгайлан заагаагүй тул шүүх сэтгэл санааны хохиролд мөнгө гаргуулсан нь дээр дурдсан хуулийн зохицуулалтад нийцээгүй, сэтгэл санааны хохиролд 20,000,000 төгрөг гаргуулах тухай хүсэлтийг хангах хууль зүйн үндэслэлгүй байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-т “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл

<sup>40</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6652/view>

<sup>41</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5546/view>

*Үргэлжлэл*

санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэхийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргах эрхтэй...” гэж заасан нь сэтгэл санааны хохиролд шаардсан 20,000,000 төгрөгийг гаргуулах үндэслэл болохгүй. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нь иргэний эрх зүйн маргааныг иргэний шүүх хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулдаг болно.

---

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-р зүйлийн 1 дэх хэсэг материаллаг эрх зүй хэм хэмжээ болох нь эхлээд уг зүйлийн “Сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах” гэх гарчгаас харагдана. Өөрөөр хэлбэл, уг зүйлийн зорилго нь материаллаг харилцааг зохицуулах болохыг сэтгэл санааны хохирлыг арилгах гэснээс нотлогдоно.

Уг зүйл материаллаг эрх зүй хэм хэмжээ болох нь энэ зүйлийн зохицуулалтын агуулгаар мөн тодорхойлогдоно. Уг зүйлийн “Эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг...” гэх хэсэг нь уг зүйлийн гол агуулга бөгөөд “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана” гэх хэсэг нь байсан байгаагүй ялгаагүй хэсэг юм. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар энэ харилцааг зохицуулдаг тул энд дахин давтаж бичих шаардлагагүй билээ. Гол нь сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргах буюу шаардах эрхийг олгож буйд материаллаг зохицуулалт агуулагдаж байна.

Хэлбэрийн хувьд эрүүгийн процесс хуульд тусгагдсан ч шууд эрүүгийн процессын эрх зүйн хэм хэмжээ гэж хэлж болохгүй. Бодит агуулгад нь тулгуурлаж эрх зүйн хэм хэмжээний шинж чанарыг тодорхойлох хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, тодорхой хэм хэмжээг ямар хуульд тусгагдсанаас үл хамаарч юуг зохицуулж байгаа вэ гэдгээр нь аль салбар эрх зүйн хэм хэмжээ болохыг тодорхойлох ёстой. Иймээс аливаа

этгээдэд учирсан хохирлыг арилгах зорилготой эрх зүйн хэм хэмжээ нь Иргэний эрх зүйн гэм хорын материаллаг хэм хэмжээ болно.

Иргэний хуулийн 230-р зүйлийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан. Уг зарчмын дагуу эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэг болон 45.4-р зүйлийн 1 дэх хэсэгт тусгайлан заасан. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах эрхтэй”, 45.4-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх...” гэж эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас үүссэн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр арилгах тухай хуульд тусгайлан заасан зохицуулалтууд байсаар байтал УДШ-ийн зүгээс ийм тайлбар хийж буй нь хууль буруу хэрэглэж буй явдал билээ. Хууль хэрэглэхдээ үг зүйн тайлбар хийх, хэм хэмжээг зорилгынх нь үүднээс авч үзэх ёстойг энд мартаж болохгүй.

ХБНГУ-ын 1896 онд батлагдаж 1900 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн Иргэний хуулийн 253-р зүйлийн 253.1 дэх хэсэгт “Зөвхөн хуульд заасан тохиолдолд эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөхийг шаардаж болно”<sup>42</sup> гэж эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудлыг хуульд тусгайлан заасан тохиолдолд хүлээн зөвшөөрөхөөр хязгаарлагдмал байдлаар хуульчилжээ. Энэ нь 18-р зууны үед сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэх явдал нь нэр төртэй үйлдэл биш бөгөөд ёс суртахуунд харш гэж үздэг хууль зүйн ухамсартай холбоотой гэж тайлбарладаг байна. Гэхдээ энэ тайлбарыг дэмжих байдал буурч харин эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлүүлэхийг ерөнхий байдлаар, бүх гэм хорын тохиолдолд хүлээн зөвшөөрөх нь шүүгчид хэт их эрх мэдэл олгож болзошгүй гэх үндэслэлийг илүү дэмжих болжээ.

Хуульд заасан тусгай тохиолдлын нэг нь тус улсын Иргэний хуулийн 847-р зүйлийн 847.1 дэх хэсэгт “Хохирогчийн бие махбод, эрүүл мэндэд халдсан болон эрх чөлөөг нь хязгаарлагдсан тохиолдолд эдийн бус

<sup>42</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_bgb/englisch\\_bgb.html#p0761](https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html#p0761)  
Section 253 (1) Money may be demanded in compensation for any damage that is not pecuniary loss only in the cases stipulated by law.

хохирлыг зохих хэмжээнд мөнгөөр нөхөн төлүүлэхээр шаардаж болно. Уг шаардах эрхийг өвлүүлэх, шилжүүлэх боломжгүй хэдий ч гэрээгээр хүлээн зөвшөөрсөн, эсвэл хэрэг маргаан хянан шийдвэрлэх явцад байсан тохиолдолд энэ хориг үйлчлэхгүй. Эмэгтэйчүүдийн эсрэг ёс зүйд харш, хүнд болон хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, хуурах, хүч хэрэглэх, захирагдах харилцааг урвуулан ашиглаж гэр бүлээс гадуур бэлгийн харилцаанд орохыг хүлээн зөвшөөрүүлсэн бол хохирогч нь мөн адил эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэх шаардлага гаргаж болно” гэсэн заалт юм. Энэ заалтыг 2002 оны Иргэний хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хүчингүй болгож Иргэний хуулийн 253-р зүйлийн 253.2 дахь хэсэгт “Бие махбод, эрүүл мэнд, эрх чөлөө эсвэл бэлгийн амьдралаа бие даан тодорхойлох эрхэнд халдсаны улмаас үүссэн хохирлыг нөхөн төлсөн бол эдийн бус хохирлыг мөн зохих хэмжээнд мөнгөөр нөхөн төлүүлэхээр шаардаж болно”<sup>43</sup> гэж агуулгыг нь өргөжүүлэн нэмж оруулсан байна.

Цаашлаад ХБНГУ-ын Үндсэн хуулийн агуулга, үзэл санаатай Иргэний хуулийн 253-р зүйл нийцэхгүй байгаа талаар маргаан өрнөжээ. Үндсэн хуулиар хамгаалагдсан хувь хүний эрхийг хангахын тулд гэм хорын эрх зүйн хамгаалалт нь хүний тодорхой хэдэн бие даасан эрхээр хязгаарлагдах нь явцуу, хангалтгүй болох нь батлагдсантай нэгэн адилаар сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхийг хэдхэн цөөн эрх зөрчигдөхөд хүлээн зөвшөөрч буй нь Үндсэн хуулиар хамгаалсан үнэт зүйлтэй нийцэхгүй байна гэх хандлага давамгайлах болж, шүүхийн зүгээс хэрэг маргаан шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 253-р зүйлийн зохицуулалтын агуулгаас давсан байдлаар хууль тайлбарлан хэрэглэх болсон байдаг.

Ийнхүү ХБНГУ-ыг жишээ болгон авч үзэхэд, манай улсын Иргэний хуулийн 230-р зүйлд заасан хуульд тусгайлан заасан тохиолдолд сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлнө гэсэн зохицуулалттай адилхан зохицуулалт тус улсын Иргэний хуулийн 253-р зүйлээр зохицуулагдаж буй боловч Үндсэн хуулийнхаа үзэл санаанд нийцүүлж уг зүйлд заасан агуулгад хатуу баригдалгүй сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлдэг.

<sup>43</sup> [https://www.gesetze-im-internet.de/englisch\\_bgb/englisch\\_bgb.html#p0761](https://www.gesetze-im-internet.de/englisch_bgb/englisch_bgb.html#p0761)  
Section 253(2) If damages are to be paid for an injury to body, health, freedom or sexual self-determination, reasonable compensation in money may also be demanded for any damage that is not pecuniary loss.

Гэтэл манай улсын шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан сэтгэл санааны үр дагаврыг арилгах талаар хуульд тусгайлан заасаар байхад хэрэглэхгүй байгаа нь хүний эрхийн мэдрэмжгүй, хууль тайлбарлан хэрэглэх чадвар дорой байгаагийн жишээ юм.

### 6.2.2 Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх эсэхтэй холбоотой шийдвэр

УДШ-ийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоолын 16-д Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 391-р зүйлийн 391.2-т зааснаар “эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно” гэдэг нь тухайн иргэний холбогдсон эрүүгийн хэргийн ангилал, энэ хэрэгт шалгагдсан болон хоригдсон хугацаа, прокурорын яллах дүгнэлт, шүүхийн шийтгэх тогтоолын агуулга, сонсгосон болон оногдуулсан ялын хэмжээ, хэрэгт шалгагдах болон ял эдлэх хугацаанд бие махбодод учирсан гэмтэл, олсон өвчин эмгэг, хэргийн болон тухайн иргэний талаар олон нийтэд түгсэн мэдээллийн цар хүрээ зэргийг харгалзан хохирлын хэмжээг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд мөнгөөр тодорхойлохыг хэлнэ<sup>44</sup> гэж тодорхойлсон байдаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас үүссэн сэтгэл санааны хохирлын хэмжээг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж шийдвэрлэнэ гэж буй нь буруу юм.

УДШ-ийн хэрэг шийдвэрлэсэн тогтоолууд дунд ч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх байдлаар хангасан тохиолдол байхын зэрэгцээ, уг заалтыг төсөөтэй хэрэглэхгүй гэж үзсэн тохиолдлууд байна.

---

<sup>44</sup> УДШ-ийн “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай” 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоол <https://www.legalinfo.mn/law/details/635?lawid=635>

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан дүгнэлт
1	2018 оны 12 сарын 04 Дугаар 001/ХТ2018/01759 <sup>45</sup>	<p>Анхан шатны шүүх О-ийн холбогдсон эрүүгийн гэмт хэргийн ангилал, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 86 дугаар зүйлийн 1, 200 дугаар зүйл гэх хоёр зүйл ангиар сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдаж, улмаар 21 жилийн хугацаанд сэжигтэн, яллагдагчаар тооцогдсон, түүнд авсан цагдан хорих, бусдын даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авагдаж байсан хугацаа зэргийг харгалзан 50,000,000 төгрөгийг нэхэмжлэгчид олгохоор шийдвэрлэснийг буруутгахгүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйлд “Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд нь мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эрүүл мэнд, сэтгэл санааны үр дагаврыг арилгуулах болон тэтгэвэр, тэтгэмж авах, орон сууц эзэмших болон бусад эрхээ нөхөн сэргээлгэх эрхтэй” гэж ямар төрлийн хохирлыг арилгуулахаар шаардах эрхийн зохицуулалтыг хийсэн байна. Түүнчлэн энэ хуульд тухайн хүнд учирсан хохирлыг мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгахыг заажээ. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлд сэтгэл санааны хохирлын үр дагаврыг арилгах журмыг тодорхойлсон байх бөгөөд эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан</p>

<sup>45</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5338/view>



журмын дагуу гаргана гэсний дагуу нэхэмжлэгч иргэний хэргийн шүүхэд хүсэлт гаргасны дагуу анхан шатны шүүх онцгой ажиллагааны журмаар хүсэлтийг хянан шийдвэрлэсэн нь процессын эрх зүйн хувьд зөв байна. Иргэний хуулийн 230 дугаар зүйлд зааснаар хохирогч эдийн бус гэм хорыг арилгуулахаар шаардах эрхтэй бөгөөд гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх тухай зохицуулсан байх бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1 дүгээр зүйл, 45.4 дүгээр зүйлд “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл” гаргах эрхийг заажээ. Хэдийгээр Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т заасан “...хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсэн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор болон шүүгчийн буруутай эсэхээс үл хамааран төр хариуцан арилгах үүрэгтэй” гэснийг мөн хуулийн 230 дугаар зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр төлүүлэх “тусгайлан заасан тохиолдол” гэж шууд дүгнэх боломжгүй юм. Нэгэнт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар “...эд хөрөнгийн бус хохирол, сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл” гаргах эрхийг нэхэмжлэгчид олгосон байхад зөвхөн Иргэний хуульд тусгайлсан зохицуулалт байхгүй гэсэн үндэслэл зааж хүсэлтийг хэрэгсэхгүй болгох нь Иргэний хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан “... иргэний эрх үүргийг ямар нэг хязгаарлалтгүйгээр

*Үргэлжлэл*

хэрэгжүүлэх, зөрчигдсөн эрхийг сэргээлгэх, шүүхээр хамгаалуулах зарчим”-д нийцэхгүй. Иймээс О-д холбогдуулсан эрүүгийн хэргийн зүйл, анги, тэрээр 134 хоног цагдан хоригдсон, 21 жилийн турш сэжигтэн, яллагдагч байсан, 21 жил таслан сэргийлэх арга хэмжээтэй байсан нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдож байх тул Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэж, 230 дугаар зүйлийн 230.2-т зааснаар нэхэмжлэгчид учирсан хохирлыг гаргуулах нь Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2-т нийцнэ. Энэ үндэслэлээр хяналтын шатны шүүхээс анхан шатны шүүхийн шийдвэрт хууль хэрэглээний нэмэлт оруулна. Эрүүгийн гэмт хэрэгт иргэнийг холбогдуулан шалгах эрх бүхий байгууллага хуульд заасан ажиллагаа явуулсан хэдий ч эцэст нь тухайн иргэн гэм буруутай болох нь тогтоогдоогүй нөхцөлд дээрх ажиллагааны улмаас үүсэх үр дагаврыг төр хариуцах үүрэгтэй бөгөөд О д учирсан хохиролд 50,073,218 төгрөгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын нөөц сангаас гаргуулан нэхэмжлэгч О-д олгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх 450,886,782 төгрөгийг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг буруутгах үндэслэл тогтоогдохгүй байна. Хяналтын шатны шүүх хуралдаан дээр О-ийн өмгөөлөгч нь 29,100,000 төгрөг болгож шаардлагаа багасгасан тухай тайлбар гаргасныг хүлээн авах боломжгүй байна. Учир нь нэгдүгээрт, тэрээр итгэмжлэгдсэн төлөөлөгч биш тул түүнд шаардлага багасгах эрх олгогдоогүй, хоёрдугаарт, хяналтын шатны шүүхэд гаргасан гомдолд О нь “...50,960,000 төгрөгөөр гомдлыг хангаж өгнө үү” гэсэн байгааг дурдах нь зүйтэй.

---

2	2017 оны 04 сарын 13 Дугаар 001/ ХТ2017/ 00432 <sup>46</sup>	<p>Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн 391.2-т эд хөрөнгийн бус хохирлын хэмжээг хэргийн нөхцөл байдлыг харгалзан Иргэний хуульд заасан журмаар тодорхойлно, 391.3-т сэтгэл санаанд учирсан хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу гаргана гэж тус тус зааснаар сэтгэл санааны хохирлыг шаардах эрхийг хуулиар тогтоосон тул энэ утгаар давж заалдах шатны шүүхийн магадлалыг буруутгах үндэслэлгүй гэж үзэв. Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө гэж заасан боловч хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан иргэнд учирсан сэтгэл санааны хохирлыг арилгах талаар хуульд тусгайлан зохицуулаагүй бөгөөд Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэсэн нь мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг зөрчөөгүй байна. Хоёр шатны шүүх Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4, 230 дугаар зүйлийн 230.2, 511 дүгээр зүйлийн 511.1 дэх хэсгийг зөв тайлбарлан хэрэглэж гэм хорыг Засгийн газрын нөөц сангаар хариуцуулахаар шийдвэрлэсэн нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагад нийцсэн тул нэхэмжлэгчийн хяналтын гомдлыг хангахгүй орхив.</p>
---	---	---

---

<sup>46</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/2545/view>

- 
- 3 2018 оны 02 сарын 02 Дугаар 001/ХТ2018/00169<sup>47</sup> Иргэний хуулийн холбогдох зохицуулалтыг баримтална. Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасан эдийн бус гэм хорыг арилгах зохицуулалтад зөвхөн бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээдийн үүргийг тусгажээ. Харин Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.1, 230.2-т зааснаар эдийн бус гэм хорыг арилгуулахаар хохирогч шаардах эрхтэй боловч гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөх боломжтой байна. Өөрөөр хэлбэл, сэтгэл санаанд учирсан хохирол буюу эдийн бус гэм хорыг хэрхэн арилгуулах талаар Иргэний хуульд тухайлсан зохицуулалт байхгүй нөхцөлд шүүх энэ талаарх шаардлагыг хангах боломжгүй юм. Анхан болон давж заалдах шатны шүүх нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангахдаа Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.1-д заасан зохицуулалтыг тухайн маргаанд төсөөтэй хэрэглэсэн нь алдаатай болжээ. Иргэний хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар Иргэний хуульд тухайн харилцааг зохицуулсан хэм хэмжээ байхгүй бол түүнтэй төсөөтэй харилцааг зохицуулсан хуулийн хэм хэмжээг хэрэглэх боловч мөн зүйлийн 4.3-т зааснаар тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно. Сэтгэл санаанд учирсан гэм хор болон нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаагдсанаас учирсан гэм хор нь эдийн бус гэх төрөлд хамаарах боловч агуулга, хэлбэрийн хувьд ялгаатай тул эдгээр харилцаанд эрх зүйн нэг хэм хэмжээг төсөөтэй хэрэглэх боломжгүй гэж үзнэ. Анхан болон давж заалдах шатны шүүх сэтгэл санааны хохиролд 18,507,000 төгрөг гаргуулахаар шийдвэрлэсэн нь дээрх үндэслэлээр хуульд нийцээгүй байна.
- 

<sup>47</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3809/view>

4	2016 оны 10 сарын 21 Дугаар 001/ ХТ2016/ 01079 <sup>48</sup>	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 391 дүгээр зүйлийн 391.1-д “...эдийн бус хохирлыг Иргэний хуульд заасан журмын дагуу нөхөн төлнө” гэж заасан боловч Иргэний хуульд энэ талаар зохицуулаагүй байна. Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг заасан тул хуулийг төсөөтэй хэрэглэх үндэслэлгүй. Иймд хүсэлт гаргагчийн шаардлагаас сэтгэл санааны хохирол 1,000,000 төгрөг гаргуулах шаардлагыг хангах боломжгүй байжээ. Харин шүүх хүсэлт гаргагчийн шаардлагад холбогдох хуулийг оновчтой хэрэглээгүйг зөвтгөх шаардлагатай гэж үзэв. Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.4-т хууль бусаар яллагдагчаар татагдсан, ял шийтгүүлсэн, баривчлагдсан, саатуулагдсан буюу гадагш явахгүй гэсэн баталгаа өгсөн, захиргааны журмаар баривчлагдсан этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээсэн тохиолдолд түүнд учирсан хохирлыг төр хариуцахаар тусгайлан зохицуулсан байхад хуулийн нийтлэг зохицуулалт болох 497 дугаар зүйлийн 497.1 дэх хэсгийг давхар хэрэглэсэн нь буруу болохоос гадна Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.3.7-д Засгийн газрын нөөц сангийн талаар зохицуулсан байх тул хүсэлт гаргагчийн шаардах эрхэд хамаарахгүй, эдгээр үндэслэлээр магадлалд өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзлээ.
---	---	--

УДШ-ээс нэг хуулийн заалтыг хоёр өөр байдлаар тайлбарлаж хэрэглэж буй нь хууль хэрэглээний тогтворгүй байдлыг бий болгож байна. Нэг үгээр хэлбэл, УДШ өөрийн оршин байгаа зорилго болох хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах гэсэн зорилгоо хэрэгжүүлж чадахгүй байгаагийн илрэл юм. Иргэний хуулийн 230-р зүйлийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан тул Иргэний хуулийн 4-р

<sup>48</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/1667/view>

зүйлийн 4.3 дахь хэсэгт “Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно” гэж заасны дагуу тусгай харилцааг тухайлан зохицуулсан Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх боломжгүй юм.

Нэгэнт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санаанд учирсан хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх...”-ээр заасан байхад тусгай харилцааг зохицуулж буй Иргэний хуулийн 511-р зүйлийг хүчээр хэрэглэх гэж оролдох нь буруу билээ. Цаашлаад Иргэний хуулийн 511-р зүйлийн 511.2 дахь хэсэгт “Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно” гэж заасан нь төсөөтэй хэрэглээд байхаар хангалттай тодорхой заалт биш юм.

Харин ч дээр дурдсан УДШ-ийн 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоолын 16-д “...тухайн иргэний холбогдсон эрүүгийн хэргийн ангилал, энэ хэрэгт шалгагдсан болон хоригдсон хугацаа, прокурорын яллах дүгнэлт, шүүхийн шийтгэх тогтоолын агуулга, сонсгосон болон оногдуулсан ялын хэмжээ, хэрэгт шалгагдах болон ял эдлэх хугацаанд бие махбодод учирсан гэмтэл, олсон өвчин эмгэг, хэргийн болон тухайн иргэний талаар олон нийтэд түгсэн мэдээллийн цар хүрээ зэргийг харгалзан хохирлын хэмжээг... нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд мөнгөөр тодорхойлох” гэсэн нь илүү дэлгэрэнгүй шалгуур үзүүлэлтийг гаргаж ирсэн байна.

### 6.2.3 Сэтгэл санааны хохирлыг үнэлэх асуудал

УДШ-ийн тогтоолуудад сэтгэл санааны хохирлыг үнэлэх тусгай зохицуулалт байхгүй учраас нэхэмжлэлийг хангах боломжгүй гэж тайлбарлах байдал ажиглагдаж байна. Мөн Улсын Дээд Шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолын 6.2.4-т “Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовуурь шаналал, сэтгэл

санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй. Иргэний хуулийн 21, 511 дүгээр зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгана”<sup>49</sup> гэж мөн энэ байр сууриа тодорхой илэрхийлжээ.

Ер нь эдийн бус гэм хор гэж юу болох талаар УДШ-ийн зөв ойлголттой байгаа нь эсэх нь эргэлзээ төрүүлж байна. Дээрх тогтоолын 6.2.4-т “...хүний амь нас, бие эрхтэн... зэрэг эдийн бус хохирлыг...” гэсэн нь эдийн бус хохирлыг буруу ойлгосны илрэл юм. Хүний амь нас, бие эрхтэн эдийн бус хохиролд ордоггүй болно. Манай улсын Иргэний хуулиар ч мөн үүнийг эдийн бус хохирол гэж үздэггүй бөгөөд харин эрхэд хамааруулдаг. Дараах УДШ-ийн тогтоолд эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг үнэлэх тухай хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй тул уг хохирлыг мөнгөөр тооцон гаргуулах боломжгүй гэж үзжээ.

---

<sup>49</sup> “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай” 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Дугаар 15 тогтоол <http://www.supremecourt.mn/act/view/24>

№	УДШ-ийн тогтоол	Тогтоолын хянавал хэсэгт тусгагдсан дүгнэлт
1	2020 оны 04 сарын 14 Дугаар 001/ ХТ2020/ 00179 <sup>50</sup>	Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан байна. Мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагаанаас учирсан эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг үнэлэх тухай хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй тул уг хохирлыг мөнгөөр тооцон гаргуулах боломжгүй. Процессын эрх зүйг зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.4 дүгээр зүйлийн 1-д болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д эдийн бус гэм хорын хохирол гаргуулахаар шүүхэд хандах эрхтэйг журамласан явдал нь тухайн нэхэмжлэлийг хангах хууль зүйн үндэслэл болохгүй.
2	2019 оны 01 сарын 24 Дугаар 001/ ХТ2019/ 00117 <sup>51</sup>	Харин гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан байна. Мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор шүүгчийн хууль бус ажиллагаанаас учирсан эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг үнэлэх тухай хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй тул уг хохирлыг мөнгөөр тооцон гаргуулсан анхан шатны шүүхийн дүгнэлт хуульд нийцээгүй байна. Процессын эрх зүйг зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд эдийн бус гэм хорын хохирол гаргуулахаар шүүхэд хандах

<sup>50</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6639/view>

<sup>51</sup> <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5566/view>



---

эрхтэйг журамласан явдал нь тухайн  
нэхэмжлэлийг хангах хууль зүйн үндэслэл  
болохгүй тул сэтгэл санааны буюу эдийн бус гэм  
хорд 6,000,000 төгрөг гаргуулах нэхэмжлэлийг  
хэрэгсэхгүй болгох нь зүйтэй байна.

---

Энэ нь мөн хуулийг буруу тайлбарлаж хэрэглэж буйтай холбоотой. Учир нь эрх зүйн хэм хэмжээний урьдчилсан нөхцөл тэр болгон нэгийг харьцах нэг утгатай байдаггүй бөгөөд ерөнхий агуулга бүхий хэм хэмжээ буюу тодорхой бус, хэрэглэгч этгээд болох шүүгчийн үнэлэлт дүгнэлтээс хамаарах ухагдахуун эрх зүйн хэм хэмжээний бүрэлдэхүүн болох тохиолдол байдаг. Тухайлбал, манай улсын Иргэний хууль дахь “нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээ”, “гэм буруу” гэсэн нэр томъёонуудыг жишээ болгож болно.

Үүний адилаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санааны үр дагавар...”, 45.4-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санаанд учирсан хор уршиг...” гэсэн нэр томъёонууд нь ерөнхий агуулга бүхий хэм хэмжээ бөгөөд хэргийг шийдэх гэж буй шүүгчийн өөрийн үнэлгээ, үзэмжээс хамааралтай ойлголтууд болно. Иймд хуульд сэтгэл санааны хохирлыг үнэлэх зохицуулалт байхгүй гэж тайлбар хийж болохгүй бөгөөд сэтгэл санааны хохирлыг шүүгч өөрөө үнэлэх ёстой юм.

Сэтгэл санааны хохирлыг тооцох арга, аргачлал хайх хэрэггүй бөгөөд шүүгч өөрийн туршлага, хохирогчийн онцлог байдлыг харгалзан хохирлын хэмжээг тогтоох ёстой. Бусад орон ч мөн сэтгэл санааны хохирлын хэмжээг тогтоох хуульчилсан арга, аргачлал байхгүй. Харин ч шүүгчид хэргийн нөхцөл байдлыг харгалзан үзэж өөрийн дотоод итгэлээр шийдвэр гаргах боломжийг олгодог байна.

ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн 287-р зүйлийн 287.1 дэх хэсэгт “Хохирол учирсан эсэх, хэр хэмжээний хохирол учирсан, эсвэл мөнгөөр нөхөн төлбөл зохих эрх ашиг зөрчигдсөн эсэх дээр талуудын хооронд маргаан байгаа тохиолдолд шүүх хэргийн бүхий л нөхцөл байдлыг харгалзан үзэж, өөрийн үзэмж, дотоод итгэлээр үүнийг

шийдвэрлэнэ”<sup>52</sup> гэж заажээ.

Япон Улсын Иргэний процессын хуулийн 248-р зүйлийн 248.1 дэх хэсэгт “Хохирол учирсан болох нь хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд хохирлын шинж чанараас шалтгаалж түүний хэмжээг нотлоход хүндрэлтэй байгаа бол шүүх нь шүүх хуралдааны хэлэлцүүлгийн ерөнхий байдал болон нотлох баримт шинжлэн судалсны үр дүнд тулгуурлан зохих хохирлын хэмжээг тодорхойлж болно”<sup>53</sup> гэж заажээ.

Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас үүссэн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчин манай улсад байгаа боловч хууль хэрэглээний алдаатай байдлаас хэрэгжихгүй байна.

---

<sup>52</sup> Investigation and determination of damages; amount of the claim

Section 287 (1) Should the issue of whether or not damages have occurred, and the amount of the damage or of the equivalent in money to be reimbursed, be in dispute among the parties, the court shall rule on this issue at its discretion and conviction, based on its evaluation of all circumstances.

[https://www.gesetze-im-internet.de/englisch\\_zpo/englisch\\_zpo.html](https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html)

<sup>53</sup> (Finding the Amount of Damage)

Article 248 If damage is found to have occurred, but, due to the nature of the damage, it is extremely difficult to prove the amount of damage that occurred, the court may reach a finding on the amount of damage that is reasonable, based on the entire import of oral arguments and the results of the examination of evidence. <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=2834&vm=&re=>

## ДҮГНЭЛТ

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгийн хохирол нөхөн төлүүлэхтэй холбоотой зохицуулалтууд дунд “хууль бус” гэх нэр томьёо хэрэглэж буй нь хуулийг буруу тайлбарлаж хэрэглэхэд хүргэж байна.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгийн зорилго нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг арилгах үүргийг төрд оногдуулж буй бөгөөд нэгэнт мөрдөгч, прокурор, шүүгчид уг үүргийг оногдуулах зорилгогүй учраас мөрдөгч, прокурор, шүүгч гэсэн нэр томьёог уг бүлгийн нэршил болон холбогдох зохицуулалтаас хасах хэрэгтэй.
- Шүүх эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэргийг шийдвэрлэхдээ Иргэний хуулийн 498-р зүйлийн 498.4 дэх хэсгийн заалтыг шаардах эрхийн үндэслэл болгож буй нь Иргэний хуулийн 3-р зүйлийн 3.3 дахь хэсгийг зөрчсөн хууль хэрэглээний алдаа юм.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай 2017 оны хуульд уг төрлийн хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх зохицуулалт байхгүй байхад УДШ-ийн зүгээс эрүүгийн хэрэг нь хэрэгсэхгүй болсон, түүнчлэн цагаатгагдсан этгээдэд гэм хор учирсан явдал нь маргаангүй үйл баримтад хамаарах тул дээрх ажиллагаанаас учирсан гэм хорыг нэхэмжлэгчийн хүсэлтээр онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэх ёстой гэж үзэж буй нь үндэслэлгүй бөгөөд хуулийг буруу тайлбарлан хэрэглэжээ.
- Хууль зүйн туслалцаа авахдаа хөлс төлсөн гэдгийг авч үзэхдээ харилцан адилгүй байдлаар үйл баримтыг үнэлсэн байна. Тухайлбал, зарим тохиолдолд төлбөр төлсөн гэх шууд үйл баримтыг тогтоож байж хохиролд тооцон нөхөн төлүүлсэн байхад, зарим тохиолдолд шууд бус үйл баримтад тулгуурлан хууль зүйн туслалцаа авахдаа төлбөр төлсөн болохыг тогтоожээ.

Гэвч энэ нь тогтворгүй байх бөгөөд ижил төстэй тохиолдлын заримд нь шууд бус үйл баримтад тулгуурлан нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэж, зарим үед хангахгүй шийдвэрлэж байгаад гол асуудал байна.

- Хүний аваагүй цалин хөлс болон амьжиргааны үндсэн эх үүсвэр болж байсан хөдөлмөрийн бусад орлогыг тооцохдоо гэм хор учирсан үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, эсвэл хэрэг хянан шийдвэрлэж буй үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг баримтлах зэрэг ялгаатай байдлаар шийдвэрлэж, хуулийг буруу хэрэглэж байна.
- Цагдан хоригдсон, эсвэл хорих ял эдэлсэн хугацааг хохирол учирсан хугацаа гэж үзэх тохиолдол байхад зарим тохиолдолд яллагдагчаар татагдсан үеэс хохирол учирсан хугацааг тооцсон, зарим тохиолдолд эрүүгийн хэрэгт шалгагдсан хугацааг хохирол учирсан хугацаа гэж үзсэн байна.
- УДШ-ийн зүгээс гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлөхийг Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т заасан учраас мөрдөгч, эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүгчийн хууль бус ажиллагаанаас учирсан эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг үнэлэх тухай хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй тул уг хохирлыг мөнгөөр тооцон гаргуулах боломжгүй гэж буй нь хууль буруу тайлбарлан хэрэглэж буй явдал билээ.
- Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх байдлаар сэтгэл санааны хохирлыг хангасан тохиолдол байхын зэрэгцээ, уг заалтыг төсөөтэй хэрэглэхгүй гэж үзсэн тохиолдлууд байна.
- Сэтгэл санааны хохирлыг үнэлэх тусгай зохицуулалт байхгүй учраас нэхэмжлэлийг хангах боломжгүй гэж хуулийг буруу тайлбарлан хэрэглэж байна.

## ЗӨВЛӨМЖ

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгийг шинэчлэн найруулах тохиолдолд холбогдох заалтаас “хууль бус, хууль зөрчсөн” гэх нэр томъёог хасах шаардлагатай.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45-р бүлгийн нэршлийг “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах” гэж нэрлэх нь зүйд нийцнэ.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх хэргийг шийдвэрлэхдээ харилцааг илүү нарийвчлан зохицуулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг шаардах эрхийн үндэслэл болговол зохино.
- Уг төрлийн хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэх тухай заалтыг 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн хэдий ч цаашид хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд энэ төрлийн хэргийг онцгой ажиллагааны журмаар шийдвэрлэхээр хуульчлах шаардлагагүй болно.
- Хууль зүйн туслалцаа авахад төлсөн хөлсийг гаргуулах нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэхдээ шүүхийн зүгээс нэгдмэл байдлаар үйл баримтыг үнэлэх шаардлагатай байна.
- Иргэний хуулиар хохирлыг тодорхойлохдоо гэм хор учирсан үеийн үнэлэмжийг баримталдаг зарчимтай болохыг анхаарах хэрэгтэй.
- Баривчлагдсан, цагдан хоригдсон, хорих ял эдэлсэн хугацааг хохирол учирсан хугацаа гэж үзэх нь зөв юм.
- Иргэний хуулийн 230-р зүйлийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан учраас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас учирсан сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлүүлэхээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх

тухай хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэг болон 45.4-р зүйлийн 1 дэх хэсэгт хууль тусгайлсан заасан гэж ойлгох ёстой.

- Иргэний хуулийн 230-р зүйлийн 230.2 дахь хэсэгт “Гагцхүү хуульд тусгайлан заасан тохиолдолд эдийн бус гэм хорыг мөнгөөр нөхөн төлнө” гэж заасан тул Иргэний хуулийн 4-р зүйлийн 4.3 дахь хэсэгт “Тусгай харилцааг тухайлан зохицуулсан хэм хэмжээг бусад харилцаанд төсөөтэй хэрэглэж үл болно” гэж заасны дагуу тусгай харилцааг тухайлан зохицуулсан Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийг төсөөтэй хэрэглэх боломжгүй юм.
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 45.1-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санааны үр дагавар...”, 45.4-р зүйлийн 1 дэх хэсэгт “...сэтгэл санаанд учирсан хор уршиг...” гэсэн нэр томъёонууд нь ерөнхий агуулга бүхий хэм хэмжээ бөгөөд хэргийг шийдэх гэж буй шүүгчийн өөрийн үнэлгээ, үзэмжээс хамааралтай тул шүүгч өөрөө үнэлэх ёстой.

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөл, <http://forum.parliament.mn/projects/86>
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын танилцуулга, <http://forum.parliament.mn/projects/86>
3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төсөлд хийсэн зардлын тооцооны тайлан, <http://forum.parliament.mn/projects/86>
4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан, <http://forum.parliament.mn/projects/86>
5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийн үр нөлөөг үнэлсэн тайлан, <http://forum.parliament.mn/projects/86>
6. ХЗҮХ “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ” Судалгааны тайлан, УБ хот, 2018 он, <http://nli.gov.mn/wp-content/uploads/2019/01/eruu.pdf>
7. Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан “Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал”, УБ хот, 2018 он
8. Б.Амарбаясгалан, Ж.Эрхэсхулан “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй” Сургалтын иж бүрэн гарын авлага 1, 2, УБ хот, 2007 он
9. Юпп Ёхоахимски “Монгол улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар”, Мюнхен хот, 2004 он
10. А.Дугармаа нар “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй” Гарын авлага, УБ хот, 2007 он
11. Д.Хуяг “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүйн үндсэн болон тулгамдсан асуудлууд”, УБ хот, 2013 он
12. Улсын дээд шүүх “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, УБ хот, 3 дахь хэвлэл, 2014 он
13. З.Мөнхжаргал “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй-тусгай анги”, УБ хот, 2014 он
14. Йоахим Кают “Монгол улсын иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй”, Анхны хэвлэл, УБ хот, 2015 он
15. Д.Ганхүрэл Монгол улсын сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх эрхийг хүлээн зөвшөөрсөн (Шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ)

16. ХЭҮК “Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт - суурин дүн шинжилгээ”, [http://www.nhrcm.gov.mn/media/documents/1431582870\\_bus-hohirlyg-nhn-tlleh-erhiyn-sudalгаа-.pdf](http://www.nhrcm.gov.mn/media/documents/1431582870_bus-hohirlyg-nhn-tlleh-erhiyn-sudalгаа-.pdf)
17. ХЗҮХ “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол”, [http://nli.gov.mn/pdf/gemt\\_hergiin\\_ulmaas\\_uchirsan\\_hohirol.pdf](http://nli.gov.mn/pdf/gemt_hergiin_ulmaas_uchirsan_hohirol.pdf)
18. Б.Мэргэн нар “Гэм буруугүй нь тогтоогдож цагаатгагдсан хэргүүд ба түүний улмаас хоригдсон иргэдийн хохирлын нөхөн төлбөр”, Шүүхийн шийдвэрийн шинжилгээ (Эмхэтгэл 1), УБ хот, 2018 он, [http://forum.mn/res\\_mat/2018/Shuukhiin\\_shiidveriin\\_analiz.pdf](http://forum.mn/res_mat/2018/Shuukhiin_shiidveriin_analiz.pdf)
19. Ж.Оюунтунгалаг “Сэтгэл санааны гэм хорыг нөхөн төлүүлэх асуудал”, Магистрын ажил, УБ, 2002 он
20. Э.Золзаяа “Сэтгэл санааны гэм хороос учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудал”, Магистрын ажил, УБ, 2016 он
21. 内田貴『債権各論』(2011年、第3版、東京大学出版会)
22. 吉村良一『不法行為法』(2010年、第1版、有斐閣)
23. 西埜章『国家補償法概説』(2008年、第1版、勁草書房)
24. 藤田広美『講義民事訴訟法』(東京大学出版会、第2版、2011)
25. 和田吉弘『基礎からわかる民事訴訟法』(商事法務、第2版、2012)
26. 新堂幸司『新民事訴訟法』(弘文堂、第5版3刷、2013年)

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХУУЛЬ ТАЙЛБАРЛАСАН ТОГТООЛ

1. “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгах тухай эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, 2006 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 45 дугаар тогтоол
2. “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай”, 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн Дугаар 15 тогтоол

## УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЭРЭГ ШИЙДВЭРЛЭСЭН ТОГТООЛ

1. 2020 оны 05 сарын 14 Дугаар 001/ХТ2020/00223, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6652/view>
2. 2020 оны 04 сарын 14 өдөр Дугаар 001/ХТ2020/00176, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6641/view>



3. 2020 оны 04 сарын 14 Дугаар 001ХТ202000179, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6639/view>
4. 2019 оны 06 сарын 20 Дугаар 001/ХТ2019/00969, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/6360/view>
5. 2019 оны 03 сарын 26 Дугаар 001/ХТ2019/00441, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5929/view>
6. 2019 оны 01 сарын 24 Дугаар 001/ХТ2019/00117, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5566/view>
7. 2019 оны 01 сарын 10 Дугаар 001/ХТ2019/00036, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5546/view>
8. 2019 оны 01 сарын 15 Дугаар 001/ХТ2019/00057, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5540/view>
9. 2018 оны 12 сарын 06 Дугаар 001/ХТ2018/01775, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5344/view>
10. 2018 оны 12 сарын 04 Дугаар 001/ХТ2018/01759, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/5338/view>
11. 2018 оны 09 сарын 25 Дугаар 001/ХТ2018/01250, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/4833/view>
12. 2018 оны 05 сарын 04 Дугаар 001/ХТ2018/00717, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/4269/view>
13. 2018 оны 03 сарын 13 Дугаар 001/ХТ2018/00407, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/4040/view>
14. 2018 оны 03 сарын 13 Дугаар 001/ХТ2018/00411, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3844/view>
15. 2018 оны 02 сарын 02 Дугаар 001/ХТ2018/00169, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/3809/view>
16. 2017 оны 06 сарын 08 Дугаар 001/ХТ2017/00759, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/2701/view>
17. 2017 оны 03 сарын 09 Дугаар 001/ХТ2017/00250, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/2253/view>
18. 2016 оны 12 сарын 20 Дугаар 001/ХТ2016/01432, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/1972/view>
19. 2016 оны 12 сарын 6-ны өдрийн Дугаар 001/ХТ2016/01336, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/1870/view>
20. 2016 оны 10 сарын 21-ний өдрийн Дугаар 001/ХТ2016/01079, <http://new.shuukh.mn/irgenhyanalt/1667/view>